

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

УУЛ УУРХАЙН ТУХАЙ

2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь ашигт малтмалыг үндэсний эрх ашигт нийцүүлэн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл багатай, эдийн засгийн үр ашигтайгаар олборлож, баяжуулж боловсруулан хариуцлагатай уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1.Уул уурхайн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар газрын хэвлийгээс ус, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмалыг эрэх, хайх, олборлох, баяжуулах, боловсруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Бичил уурхайн асуудлыг Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-т заасан журмын дагуу зохицуулна

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төрийн захиргааны төв байгууллага” гэж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг;

4.1.2.“төрийн захиргааны байгууллага” гэж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

4.1.3.“геологийн судалгаа” гэж муж, бүс, талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалт, түүний зүй тогтолыг судлах зорилготой бүх масштабын талбайн геологийн судалгаа, зураглал, ерөнхий эрэл, бусад сэдэвчилсэн судалгаа хийхийг;

4.1.4.“эрэл” гэж геологийн судалгааны үр дүнд ашигт малтмалын хэтийн төлөв бүхий гэж үнэлэгдсэн талбайн геологийн бүтцийг тогтоож, ашигт малтмалын төрөл, найрлага, байршил, баялаг, нөөцийн тойм хэмжээг үнэлэх, түүнийг цаашид үргэлжлүүлэн хайгуул хийх эсэхийг тодорхойлох зорилгоор шаардагдах бүх төрлийн геологи, геохими, геофизик, уулын малталт, өрөмдлөг, дээжлэлт, сорьцлолт, лабораторийн болон бусад ажлыг холбогдох заавар, журмын дагуу хийж гүйцэтгэх цогц үйл ажиллагааг;

4.1.5.“хайгуул” гэж эрлийн ажлын үр дүнд хэтийн төлөвтэй гэж тодорхойлогдсон талбайд ашигт малтмалын биетийн хэлбэр хэмжээ, байршил, найрлага, баяжигдах чанар, геологийн бүтэц, ашигт малтмал олборлох уул техникийн нөхцлүүдийг нарийвчлан тогтоож, нөөц, баялгийн тоо хэмжээг тооцоолох, түүнийг цаашид олборлох эсэхийг шийдэх зорилгоор шаардагдах бүх төрлийн геологи, геохими, геофизик, уулын малталт, өрөмдлөг, дээжлэлт, сорьцлолт, лабораторийн болон бусад ажлыг холбогдох заавар, журмын дагуу хийж гүйцэтгэх цогц үйл ажиллагааг;

4.1.6.“уурхай” гэж ашигт малтмалын ордод олборлолт явуулж буй газар, олборлолт явуулахтай холбогдуулан барьж байгуулсан дэд бүтэц, барилга байгууламжийн цогцолборыг;

4.1.7.“ил уурхай” гэж ашигт малтмалын дээр орших хөрс, чулуулгийг зайлуулан ашигт малтмал олборлодог уурхайг;

4.1.8.“далд уурхай” гэж ашигт малтмалын ордын дээрх хөрс, чулуулгийг зайлуулалгүйгээр тусгайлан бэлдсэн амаар ашигт малтмал олборлодог уурхайг;

4.1.9.“уулын үйлдвэр” гэж уурхай, баяжуулах үйлдвэрийг хамтад нь эсвэл баяжуулах үйлдвэрийн цогцолборыг;

4.1.10.“уурхайн барилга, байгууламж” гэж уул уурхайн үйлдвэрлэл явуулах зориулалтаар барьж байгуулсан барилга, байгууламжийг;

4.1.11.“уурхайн дэд бүтэц” гэж уул уурхайн үйлдвэрлэлийг хэвийн явуулахад шаардлагатай бүх төрлийн зам, эрчим хүчний шугам, эрчим хүчний эх үүсвэр, холбоо мэдээллийн шугам, усан хангамжийн цогцолборыг;

4.1.12. “уурхайн эзэмшил газар” гэж уурхайн мэдэлд ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг;

4.1.13. “уурхайн ус” гэж уурхайн бэлтгэл ажил, олборлолтын явцад гүнээс шүүрч гарч ирсний улмаас уурхайн талбай, малталтад хуримтлагдсан усыг;

4.1.14. “уул уурхайн үйлдвэрлэл” гэж ашигт малтмал олборлох, баяжуулах үйл ажиллагааг хамтад;

4.1.15. “ашигт малтмал ашиглах” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7-д зааснаас гадна биежүүлэх, боловсруулах үйл ажиллагааг;

4.1.16. “олборлолт” гэж газрын хэвлийгээс ашигт малтмалыг ухаж, ачиж, тээвэрлэхийг;

4.1.17. “ашигт малтмал баяжуулах” гэж тусгай технологийн дагуу нэгжид ногдох ашигт агуулгыг нэмэгдүүлэн дараагийн шатны боловсруулалтын түүхий эд болох хагас боловсруулсан бүтээгдэхүүн, баяжмал үйлдвэрлэх үйл ажиллагааг;

4.1.18. “ашигт малтмал боловсруулах” гэж ашигт малтмалын хүдэр, баяжмалыг металлургийн болон химийн үйлдвэрийн түүхий эд болгож ашиглахад тохиромжтой хэлбэр, шинж чанар олгох зорилгоор хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон үүсмэл ордоос шууд бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг;

4.1.19. “уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн” гэж олборлолт, баяжуулалт, боловсруулалтын үр дүнгээр гарсан бүтээгдэхүүнийг;

4.1.20. “эрдэс, түүхий эд” гэж уурхайгаас олборлосон ашигт малтмалыг;

4.1.21. “баяжмал” гэж баяжуулалтын үр дүнд буй болсон нэгжид ноогдох ашигт агуулга нь нэмэгдсэн уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг;

4.1.22. “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үндэслэл” гэж эрэл, хайгуулын ажлаар илрүүлсэн эрдсийн баялгийн хэрэглээний зах зээлийн үнэлгээ, түүн дээр тулгуурлан төсөл хэрэгжүүлэх эдийн засгийн боломжийн талаар тойм судалгаа, хязгаарлагдмал хэмжээний туршилт, шаардлагатай зарим инженерийн болон эдийн засгийн тооцооны үр дүнг нэгтгэсэн баримт бичгийг;

4.1.23. “Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл” гэж ашигт малтмалын ордын нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зорилгоор хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан уул уурхайн

(ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төсөл хэрэгжүүлэх хувилбаруудын техник, технологийн боломж, эдийн засгийн үр ашгийг тооцсон баримт бичгийг;

4.1.24. "ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл" гэж улсын бүртгэлд бүртгэгдсэн баттай А', бодиттой В' нөөцөд тулгуурлан уул уурхайн (ашигт малтмал олборлох; баяжуулах, боловсруулах) төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн уулын үйлдвэрийн техник, технологийн сонголт, тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрх зүй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг;

4.1.25."тусгай зөвшөөрөлгүй этгээдийн техник, эдийн засгийн үндэслэл" гэж бусдаас эрдэс түүхий эдийг худалдан авч баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, технологийн сонголт, тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрх зүй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг;

4.1.26."уулын ажлын төлөвлөгөө" гэж уурхай, уулын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг;

4.1.27."уулын ажлын тайлан" гэж тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэсэн тухай тайланг;

4.1.28."анхан шатны тайлан" гэж ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн ил тод байдалтай холбоотойгоор гаргасан тайланг;

4.1.29."нэгдсэн тайлан" гэж Ил тод байдлын Ажлын албанаас эрх олгосон байгууллагаас анхан шатны тайланг нэгтгэсэн тайланг;

4.1.30."мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч" гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасныг;

4.1.31."төсөл боловсруулагч" гэж төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрх бүхий, Монгол улсын зөвлөх, мэргэшсэн инженер холбогдох бусад мэргэжилтнээс бүрдсэн баг бүхий хуулийн этгээдийг;

4.1.32. “төсөл хэрэгжүүлэгч” гэж төрийн захиргааны байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг;

4.1.33. “үнэлгээчин” гэж ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх чадвартай, холбогдох ашигт малтмалын ордын техникийн үнэлгээ хийж байсан туршлагатай, эсвэл холбогдох ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний талаар туршлагатай мэргэжилтэнд тулгуурласан, үйл ажиллагаа явуулж байгаа эрх бүхий мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлтэй, тухайн байгууллагад захирагддаг хүнийг;

4.1.34. “хаягдсан уурхай” гэж тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль, журмын хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэлгүй уурхай ба үйлдвэрийн байгууламжийн үйл ажиллагааг зогсоож орхисон уурхайг,

4.1.35. “нөлөөллийн талбай” гэж уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа, эсвэл үйлдвэрийн байгууламжийн үйл ажиллагаа зогссоны дараа байгаль орчны бүрдэл хэсэг нь тэдгээрийн нөлөөлөлд өртөх талбай буюу газар нутгийг;

4.1.36. “хэсэгчилсэн хаалт хийх” гэж уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үйл ажиллагааны явцад хэрэгжүүлж хаалтын санхүүгийн баталгаанаас хасалт хийхийг;

4.1.37. “бүрэн хаалт хийх үе шат” гэж уурхайн хаалтын төлөвлөгөөнд тусгагдсан бүх арга хэмжээнүүдийг уул уурхайн үйл ажиллагаа явагдсан бүх талбай ба түүнд ашиглагдсан бүх байгууламж дээр хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүнг эрх бүхий байгууллага нотолж сертификат олгох хүртэлх уул уурхайн төслийн үе шатыг;

4.1.38. “эрх бүхий этгээд” гэж төрийн захиргааны байгууллагын даргыг;

4.1.39. “уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж” гэж шууд өөрийн байгуулсан компаниар болон гэрээний үндсэн дээр туслан гүйцэтгэгчээр дамжуулан шууд бусаар эрдэс баялаг олборлох, баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа явуулж буй уурхайн хаалттай холбоотой хариуцлага хүлээх этгээдийг;

4.1.40. “физик тогтвортой байдлыг хангах” гэж уул уурхайн үйл ажиллагаа явагдсан газарт эвдрэл, нурал, гулсалт явагдахаас сэргийлэх арга хэмжээ авч хажуугийн тогтворжилтыг хангах, хэлбэржүүлэх, нягтруулах болон бусад арга хэмжээ авч геотехникийн үзүүлэлтүүдийг сайжруулах, барилга байгууламжуудыг буулгаж зайлуулах зэргийг;

4.1.41. “химийн тогтвортой байдлыг хангах” гэж ус, агаар, хөрсний химийн найрлага, шинж чанарт өөрчлөлт орохоос зайлсхийх арга замуудыг төслийн шийдлүүдэд тусгах, урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд уг өөрчлөлтийг арилгах арга хэмжээ авахыг болон уурхайн малталт, чулуулгийн овоолго, боловсруулах үйлдвэрийн хаягдал, бусад эх үүсвэр дээр химийн урвалын явагдах эрсдэлтэй бол уг газруудыг гадаргын ба гүний устай харилцан үйлчлэлд орохоос сэргийлэх зэргийг;

4.1.42. “хаалтын санхүүгийн баталгаа” гэж энэхүү хууль ба холбогдох журмын хүрээнд уурхайн хаалтын төлөвлөгөөгөөр тодорхойлсон үүргүүдийг биелүүлэх талаар гэрээгээр хүлээсэн үүрэг, уг үүргийг хангуулах зорилгоор ашиглах санхүүгийн хэрэгслийг;

4.1.43. “уул уурхайн төсөлд материаллаг өөрчлөлт орох” гэж техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлсон уул уурхайн үйл ажиллагаа явагдах хугацаа 10%-иар өөрчлөгдөх, уурхайн хүчин чадал, ашиглах, боловсруулах арга технологи өөрчлөгдөх, нөөц өөрчлөгдөх, хаягдал хаях арга технологи өөрчлөгдөх зэрэг хаалтын төлөвлөгөөний шийдлүүдийг цаашид хэвээр үргэлжлүүлэхэд хаалтын үр дүн анх тохирсон/төсөөлсөн хэмжээнд гарахааргүй болж болзошгүй байдлыг;

4.1.44. “уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа” гэж ашигт малтмалыг ил, далд аргаар олборлох, баяжуулах, боловсруулах, бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг бүхэлд нь;

4.1.45. “уурхайн үйл ажиллагааг түр зогсоох” гэж тусгай зөвшөөрлийн талбай дахь үйл ажиллагаа бүрэн буюу хэсэгчилсэн байдлаар үйл ажиллагаагаа зогсоох, энэ нь уурхай, үйлдвэр, дэд бүтцийн байгууламжийг мөн тодорхой байдлаар хамрахыг;

4.1.46. “уурхайн хаалт” гэж уурхай, уулын үйлдвэрийг хаалтын төлөвлөгөөний дагуу шалгуур үзүүлэлтэд хүргэж хаалтын барьцаанаас чөлөөлөгдөж хаалтын гэрчилгээ авахыг;

4.1.47. “уурхайн хаалтын менежмент” гэж уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах, хаалтын төлөвлөгөөний биелэлтийг хангах, хаалт хийх, хаалтын дараах хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулахыг;

4.1.48. “уурхайн хаалтын төлөвлөгөө” гэж уурхайн үйл ажиллагааны улмаас түүнд шууд хамааралтай хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй эрсдэлүүдийг хянаж, удирдах, үйл ажиллагаа явагдаж буй орчинд физик ба химийн тогтвортой байдлыг хангах үүднээс уул уурхайн компани үйл ажиллагааны эхнээс авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.49. “хаалтын дараах үе шат” гэж хаалтын төлөвлөгөөнд заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэний дараагаар тэдгээрийн үр дүнг хянаж, физик ба химийн тогтвортой байдлыг хангасныг баталгаажуулахад чиглэсэн мониторинг хийх хугацааг;

4.1.50. “гэнэтийн хаалт” гэж уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ханшны унасан, давагдашгүй хүчин зүйл тохиолдсон, уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж дампуурсан зэргээс шалгаалан уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоосныг;

4.1.51. “оролцогч тал” гэж төрийн байгууллага, уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага, иргэдийг;

4.1.52. “хаалтын баталгааны гэрчилгээ” гэж энэхүү хууль ба холбогдох журмын хүрээнд уурхайн хаалтын төлөвлөгөөгөөр тодорхойлсон үүргүүдийг биелүүлэх талаар гэрээгээр хүлээсэн үүрэг, уг үүргийг хангуулах зорилгоор ашиглах санхүүгийн хэрэгслийг баталгаажуулсан баримт бичгийг;

4.1.53. “бага эрсдэлтэй уурхай, уулын үйлдвэр” гэж хүчин чадлын хувьд бага, олборлосон бүтээгдэхүүнийг баяжуулж боловсруулахад химийн бодис, урвалж шаардагдахгүй, түгээмэл, ердийн ашигт малтмалын орд ашиглах уурхай, уулын үйлдвэрийг.

4.1.54. “хадгалах тусгай зөвшөөрөл” гэж нарийвчилсан болон гүйцээх хайгуулын ажил явуулах, технологи сонгох туршилт явуулах, ордыг ашиглах зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, хаалтын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ боловсруулах, хагас үйлдвэрлэлийн туршилт хийх, уурхай барьж байгуулах дэд бүтцийг бүрдүүлэх, хаалтын барьцааны эх үүсвэр болон хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх, зах зээлийн таатай нөхцөл бүрдэхийг хүлээх үеийг

5 дугаар зүйл. Ашигт малтмалын өмчлөлийн харилцаа

5.1. Ашигт малтмал нь Ашигт малтмалын тухай хуулийн 5.1-д зааснаар төрийн өмч бөгөөд мөн хуулийн 5.2-д зааснаар төр өмчлөгчийнхөө хувьд ашиглах эрхийг бусдад олгох эрхтэй байна.

5.2. Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу ашиглах эрх авсан хуулийн этгээд ашигт малтмалыг олборлох, баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа явуулж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлснөөр ашигт малтмалын бүтээгдэхүүнийг захиран зарцуулах эрх үүснэ.

5.3.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөөгүй тохиолдолд ашигт малтмалын бүтээгдэхүүнийг барьцаалах, хадгалахыг хориглоно.

6 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн ангилал

6.1.Уурхай, уулын үйлдвэрийг хүчин чадал, бүтээгдэхүүний борлуулалтын хэлбэр, баяжуулалтын төрлөөс хамааруулан дараах байдлаар ангилна.

6.1.1.Улсын хэмжээний буюу эрсдэл ихтэй;

6.1.2.Бүс нутгийн хэмжээний буюу дунд зэргийн эрсдэлтэй;

6.1.3.Орон нутгийн хэмжээний буюу эрсдэл багатай;

6.1.4.Бичил уурхай.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Уул уурхайн талаарх төрийн зохицуулалт

7 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

7.1.Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох.

7.2.Ашигт малтмалын олборлох, боловсруулахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих.

8 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

8.1.Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх.

8.2.Ашигт малтмалын олборлох, боловсруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

8.3.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ашигт малтмалын хөтөлбөр батлах.

8.4.Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, Далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийг тус тус батлах.

8.5.Уурхайн хаалтад зориулж тусгай бонд гаргах асуудлыг шийдвэрлэх.

9 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.

9.2.Уурхай, уулын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийг олгох.

9.3.Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг батлах.

9.4.Баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох журам батлах.

9.6.Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах.

9.7.Уул уурхайн аврах албаны дүрэм, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аврах ажиллагааг зохион байгуулах журам, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах зааварыг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран батлах.

9.8.Ашигт малтмал хил нэвтрүүлэх, экспортлоход дагаж мөрдөх журам батлах.

9.9.Далд уурхайн барилга байгууламжийг зураг төслийн дагуу хүлээн авч байнгын ашиглалтад оруулах.

9.10.Олборлосон алтыг бүртгэх, хадгалах, тээвэрлэх, худалдах үлгэрчилсэн журмыг батлах.

9.11.Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд тавигдах шаардлагыг батлах.

9.12.Уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах, хүлээн авах журам батлах.

9.13.Уурхайн хаалтын санхүүгийн баталгаа, хаалтын сангийн журмыг байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.

10 дугаар зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1.Уурхайн хаалтад зориулж тусгай бонд гаргах, арилжаалах, захиран зарцуулах журмыг батлах.

11 дүгээр зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

11.1. Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөг батлахад оролцох.

11.2. Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын комиссын бүрэлдэхүүнд оролцох.

11.3. Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд оролцох.

11.4. Нөхөн сэргээлтийн ажлын нэгж га талбайд ногдох зардлын хэмжээг нутаг дэвсгэрийн бүсчлэл, ашигт малтмалын төрлөөс нь хамааруулан ялгавартай тогтоох.

12 дугаар зүйл. Хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

12.1. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.

12.2. Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих.

13 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

13.1. Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм, Далд уурхайн аюулгүй байдлын дүрэм, Баяжуулах үйлдвэрийн аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилтийг хангуулах.

13.2. Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, баланс гаргах маягтын загварыг баталж мөрдүүлэх.

13.3. Энэ хууль, дагалдах журмын хүрээнд уурхайн хаалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний тодотголыг хүлээн авах шийдвэр гаргах, бүртгэх, хадгалах, холбогдох /оролцогч талуудад нээлттэй байлгах.

13.4. Уурхайн хаалтын зардлыг батлах, хаалтын баталгааны хэлбэрийг тохирох, уурхайн үйл ажиллагааны явцад хаалтын баталгаа хүрэлцэж буй эсэхийг хянах, хэсэгчилсэн хаалттай уялдуулан хаалтын баталгааг шинэчлэх, хаалтын төлөвлөгөө бүрэн хэрэгжсэний дараагаар хаалтын баталгаанаас чөлөөлөх шийдвэр гаргах.

13.5. Уурхайн хаалтын батлагдсан төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх.

13.6. Хаалтын төлөвлөгөөний бодит хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд хаалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төв байгууллагатай хамтран шийдвэрлэх.

13.7.Хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хэрэгжилт хангалтгүй гэж үзвэл хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авах.

13.8.Хаалтын төлөвлөгөө зөрчигдсөн талаар дүгнэлт гаргах.

13.9.Хаягдсан уурхайн талаар дүгнэлт гаргах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх.

13.10.Төрийн захиргааны байгууллага нь уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн ирүүлсэн дараах баримт бичгийг хүлээн авч шийдвэрлэнэ:

13.10.1.техник, эдийн засгийн үндэслэлийг 90 хоногийн дотор;

13.10.2.хаалтын төлөвлөгөөг 180 хоногийн дотор;

13.10.3.байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 90 хоногийн дотор.

13.11.Энэ хуулийн 6.1.2-6.1.3-д заасан бүс нутгийн хэмжээний буюу дунд зэргийн эрсдэлтэй, орон нутгий хэмжээний буюу эрсдэл багатай уурхай, уулын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, хаалтын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний асуудлыг шийдвэрлэх.

13.12.Хаалт хийгдсэн, орхигдсон, хаалтын дараах мониторингод буй уурхай, уулын үйлдвэрийн талаар мэдээллийн сан үүсгэж түүнийг олон нийтэд нээлттэй байлгана.

14 дүгээр зүйл. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

14.1.Уул уурхайн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах.

14.2.Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөтэй танилцаж санал өгөх.

14.3. Хаалтын дараах хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулах.

15 дугаар зүйл. Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоо

15.1.Энэ хуулийн 9.2-т заасан тусгай зөвшөөрөл олгоход оролцох.

15.2.Энэ хуулийн 9.4-т заасан журмын дагуу баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгчид эрх олгох.

15.3.Энэ хуулийн 64 дүгээр зүйлд заасан чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсноор гүйцэтгэх.

15.4.Энэ хуулийн 67 дугаар зүйлд заасан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох.

15.5.Үнэлгээчний эрх олгох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Ашигт малтмалын эрэл, хайгуулын ажил

16 дугаар зүйл. Геологийн судалгааны зорилго, зорилт, санхүүжилт

16.1.Геологийн судалгааны зорилго нь нутаг дэвсгэрийн геологийн тогтоцыг судлах, түүн дэх ашигт малтмалын тархалт, түүний зүй тогтолыг тогтоосны үндсэн дээр хэтийн төлөв бүхий бүс, дүүрэг, талбай, орд, илрэл, эрдэсжсэн цэг, гажлуудыг илрүүлэх, үнэлэх замаар эх орны эрдэс баялгийн сан хөмрөгийг баяжуулах төдийгүй улс орны нийгэм-эдийн засаг, бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, цаашдын хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлал, төрийн бодлогыг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх болон бусад хөгжлийн тулгуур асуудлуудад шаардлагатай үндсэн суурь мэдээллийг бэлтгэхэд оршино.

16.2.Геологийн судалгааны ажлын зорилт нь илрүүлсэн ашигт малтмалын баялгийг үнэлэх, ордын нөөцийг тооцоолон тогтооход оршино.

16.3.Геологийн судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ба хувийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

17 дугаар зүйл. Геологийн судалгааны ажлын үе шат

17.1.Геологийн судалгааны ажил нь дараах үндсэн үе шаттай байна.

17.1.1.геологийн судалгааны ажил;

17.1.2.эрлийн ажил;

17.1.3.хайгуулын ажил.

17.2.Геологийн судалгааны ажлын үе шатанд төрөл бүрийн масштабын геологи, геохими, геофизик, гидрогеологийн талбайн судалгаа, зураглалууд, сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

17.3.Эрлийн ажлыг ерөнхий эрэл, нарийвчилсэн эрэл, эрэл-үнэлгээний ажил гэсэн дэс дарааллаар гүйцэтгэнэ.

17.4.Хайгуулын ажил нь урьдчилсан ба нарийвчилсан хайгуул, ашиглалтын хайгуулын ажлаас бүрдэнэ.

17.5.Эрлийн ажлын үе шатанд геологийн тогтоц, ашигт малтмалын төрөл болон үр дүнтэй уялдуулан зураглалын ажлыг хамруулан гүйцэтгэж болно.

17.6.Урьдчилсан хайгуулын ажлыг хийхгүйгээр нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж болно.

18 дугаар зүйл. Геологийн судалгаа

18.1.Геологийн судалгааны ажлыг “Газрын хэвлийн тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Цөмийн энергийн тухай” хуулиар тус тус зохицуулна.

19 дүгээр зүйл. Эрлийн ажил

19.1.Эрлийн ажлын зорилго нь ашигт малтмалын хуримтлал бүхий талбайг ялгах, түүний хэтийн төлөвийг тодорхойлж, цаашид хайгуулын ажил хийх эсэхийг тодорхойлох, эдийн засгийн ач холбогдлыг урьдчилан үнэлэхэд оршино.

19.2.Эрлийн ажлаар тухайн талбайн маршрут, геохими болон геофизикийн ажлыг дагалдах дээжлэлт, сорьцлолтын хамт явуулах, ашигт малтмалын биетийн тархалтыг судлах зорилгоор цөөн тооны гадаргуугийн уулын малталт, өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэж, эрдэс, геохимийн сарнилын хүрээ, геофизикийн гажлыг судалсан байна.

19.3.Эрлийн ажлын үр дүнд тухайн ашигт малтмалын төрлийг тодруулж, баялгийг үнэлэх бөгөөд үндэслэлтэй тохиолдолд боломжтой нөөцийг тооцоолно.

19.4.Ерөнхий эрлийн ажлыг дангаар нь болон геологийн 1:50000-ны масштабтай зураглалын ажилтай хавсруулан гүйцэтгэнэ.

19.5.Хувийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрлийн ажлыг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгосон хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд гүйцэтгэнэ.

20 дугаар зүйл. Хайгуулын ажил

20.1.Эрэл, үнэлгээний ажлын үр дүнд хэтийн төлөвтэй болох нь тогтоогдож ашигт малтмалын баялгийг үнэлсэн талбайд дараагийн шатны ажлыг явуулан нөөцийг тогтоож ашиглалтанд бэлтгэх зорилгоор хайгуулын ажлыг явуулна.

20.2.Хайгуулын ажил нь дараах дэс дараалал, үе шаттай байна:

20.2.1.урьдчилсан хайгуул;

20.2.2.нарийвчилсан хайгуул;

20.2.3.ашиглалтын хайгуул.

20.3.Урьдчилсан хайгуулын ажлын үр дүнд ордын геологийн тогтоц, эрдсийн түүхий эдийн дундаж чанар, технологийн шинж чанар, уул техникийн нөхцлийг ерөнхий түвшинд тодорхойлсоны үндсэн дээр тухайн ордод геологи-эдийн засгийн ерөнхий үнэлгээг хийж, ордын нөөцийг шаардлагын түвшинд тогтооно.

20.4.Нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнд ордын геологийн тогтоц, ашигт малтмалын төрөл, гарал үүсэл, хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ, хувирал, өөрчлөлт, агуулга, эрдэс-бодисын бүрэлдэхүүн, найрлага, технологийн шинж чанар, гидрогеологи, инженер-геологи, геотехникийн судалгаа, геоэкологи, уул техникийн нөхцөл бусад нөхцлийг ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалын шаардлагын түвшинд судалж тогтооно.

20.5.Ашигт малтмалын ордын нөөц, баялгийг Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.17-д заасан ангиллын дагуу тооцоолж, үнэлсэн байна.

20.6.Ашигт малтмалын ордыг ашиглахад шаардлагатай ахуйн болон үйлдвэрийн усан хангамжийн эх үүсвэр, шаардлагатай барилгын материалын түүхий эдийн талаар холбогдох судалгааг хийсэн байна.

20.7.Ашиглалтын хайгуулыг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ашиглалтын хайгуул, ашиглалтын гүйцээх хайгуул гэсэн хоёр чиглэлээр гүйцэтгэнэ.

20.8.Ашиглалтын хайгуулын ажил нь ашиглалтын үед уулын үйлдвэрийн ажлыг жигд, хэвийн нөөцөөр хангах болон ордын нөөцийн хэтийн төлөвийг хангах зорилготой хийгдэнэ.

20.9.Ашиглалтын үед уулын үйлдвэрийн ажлыг жигд, хэвийн нөөцөөр хангах гэж олборлолт явуулах болон явуулж байгаа, нарийвчилсан хайгуулын ажлаар нөөц нь тооцоологдсон, ашигт малтмалын биет, үе, давхаргаас дээж, сорьц авах болон бусад аргаар чанарыг тодорхойлохыг хэлнэ. Энэ хайгуул нь олборлолтын ажилтай хамт явагдана.

20.10.Хэтийн төлөвийг хангах гэж олборлолт явуулахаар төлөвлөсөн бөгөөд нарийвчилсан хайгуулын ажлаар нөөц нь тооцоологдсон ашигт малтмалын биет, үе, давхаргын хэмжээнд хайгуулын ажлыг гүйцэтгэн нөөцийн тоо хэмжээг өсгөн, түүний зэргийг дээшлүүлэхийг хэлнэ. Хэтийн төлөвийг хангах ашиглалтын хайгуулыг олборлолтын ажлаас тодорхой хугацаагаар түрүүлж хийгдэх зарчмаар гүйцэтгэнэ.

20.11.Ашиглалтын дагалдах хайгуул нь олборлолтын явцад тогтмол, байнгын хяналт тавих үүрэгтэй бөгөөд ашигт малтмалыг нь бүрэн олборлож дууссан эсэхийг шалган баталгаажуулна.

20.12.Ашиглалтын дагалдах хайгуулын ажлын үр дүнд:

20.12.1.нөөц тооцоолсон хайгуулын ажлыг шалган баталгаажуулна;

20.12.2.ордын нөөцийн зэрэглэлийг дээшлүүлнэ.

20.13.Ашиглалтын гүйцээх хайгуулын ажлын үр дүнд ордын ашигт малтмалын нөөцийн тоо, хэмжээг өсгөн нэмэгдүүлнэ.

20.13.1.Ашиглалтын гүйцээх хайгуул гэж нарийвчилсан хайгуулын ажлын үед баялгаар үнэлэгдсэн ашигт малтмалын биет, үе, давхаргын геологийн тогтоц, ашигт малтмалын төрөл, гарал үүсэл, хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ, хувирал, өөрчлөлт, агуулга, эрдэс-бодисын бүрэлдэхүүн, найрлага, технологийн шинж чанар, гидрогеологи, инженер-геологи, геоэкологи, олборлох уул техникийн нөхцөл болон бусад нөхцлийг ордын нөөцийн ангилалын шаардлагын түвшинд судалж тогтоохыг хэлнэ.

20.13.2.Ашиглалтын гүйцээх хайгуулыг тухайн ордыг олборлох үед ашиглалтын дагалдах хайгуултай зэрэг гүйцэтгэнэ.

20.14.Хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын ордын геологийн баттай болон бодитой нөөцөд тулгуурлан тухайн ордыг ашиглах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж болно.

20.15.Ашигт малтмалын ордын геологийн боломжтой нөөцийг тогтоосон хайгуулын ажлын арга, аргачлал нь холбогдох заавар, шаардлагыг хангаж байвал тухайн ордыг ашиглах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах боломжтой.

20.16.Геологийн нөөцийн олборлоход эдийн засгийн хувьд үр ашигтай баттай ба бодитой нөөцийг үйлдвэрлэлийн нөөц гэж үзэх бөгөөд түүнд тулгуурлан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

20.17.Хайгуулын ажлыг тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

21 дүгээр зүйл. Ашигт малтмалын ордын нөөцийн хөдөлгөөн

21.1.Ашигт малтмалын ордын нөөцийн хөдөлгөөнд тухайн жилд олборлосон ашигт малтмал, хаягдлын хэмжээ, ашиглалтын хайгуулын үр дүнд өссөн, буурсан нөөцийг тооцно.

21.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн ордын нөөцийн хөдөлгөөнийг хийж, шаардлагатай мэдээллийг энэ хуулийн 21.5-т заасан журмын дагуу гаргаж төрийн захиргааны байгууллагад Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.2-т заасан хугацаанд хүргүүлнэ.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасны дагуу ирүүлсэн нөөцийн хөдөлгөөнийг нэгтгэж, нэгтгэсэн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

21.4.Төрийн захиргааны байгууллага нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний талаар шийдвэр гарган Ашигт малтмалын нөөцийн улсын балансыг хөтөлнө.

21.5.Ашигт малтмалын ордын нөөцийн хөдөлгөөн хийх журмыг Төрийн захиргааны байгууллага батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд тавигдах үндсэн шаардлага, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ

22 дугаар зүйл. Техник, эдийн засгийн үндэслэл

22.1.Ашигт малтмалын ордыг түшиглэн байгуулах уурхай болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл нь тухайн ордод тохирох техник, технологийн оновчтой шийдлийг эдийн засгийн хамгийн өгөөжтэй хувилбараар тооцоолсон, уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгчийн төслийн хэрэгжилтийн бүх үед шатанд мөрдөх үндсэн баримт бичиг байна.

22.2.Ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд хайгуулын ажлын үр дүнд тогтоогдсон геологийн нөөцөөс эдийн засгийн хувьд үр ашигтай байх нөөцийг үйлдвэрлэлийн зэрэгт шилжүүлсэн байна.

22.3.Энэ хуулийн 6.1.1-д заасан улсын хэмжээний буюу эрсдэл ихтэй уурхай болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж энэ хуулийн 22.5-д заасан болон холбогдох бусад асуудлаар дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэхээр төрийн захиргааны байгууллагын даргад уламжилна.

22.4.Энэ хуулийн 6.1.2-д заасан бүс нутгийн хэмжээний буюу дунд зэргийн эрсдэлтэй, мөн хуулийн 6.1.3-д заасан орон нутгийн хэмжээний буюу эрсдэл багатай уурхай болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж хүлээн авч дүгнэлт гарган шийдвэрлэх санал боловсруулна.

22.5.Энэ хуулийн 22.3, 22.4-т заасан дүгнэлтийг үндэслэн гаргах шийдвэртээ төрийн захиргааны байгууллагын дарга дараах асуудлыг тусгана.

22.5.1.тухайн техник, эдийн засгийн үндэслэлээр тогтоосон үйлдвэрлэлийн зэргийн нөөцийг бүртгэх;

22.5.2.техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгох хугацаа;

22.5.3.ашиглалтын болон гүйцээх хайгуулын ажилтай холбоотой асуудал;

22.5.4.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжийн дүгнэлтэд заасан холбогдох бусад асуудал;

22.5.5.тусгай зөвшөөрлийн хадгалалтын нөхцөл.

22.6.Техник, эдийн засгийн үндэслэл нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

22.6.1.төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна;

22.6.2.техник, эдийн засгийн үндэслэлийг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрх бүхий хуулийн этгээд боловсруулсан байна;

22.6.3.техник, эдийн засгийн үндэслэлийг тухайн чиглэлээр технологи мэргэжил эзэмшсэн, Монгол Улсын зөвлөх инженер удирдаж боловсруулсан байна;

22.6.4.тухайн ашигт малтмалын ордыг эдийн засгийн өндөр үр ашигтай ашиглаж болох хамгийн оновчтой техник, технологийг сонгож тооцсон байна;

22.6.5.тухайн тусгай зөвшөөрлийн талбайд ногдох ашигт малтмалын геологийн нөөцөөс техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоогоор ордын нөөцийг бүхэлд нь буюу хэсэгчлэн олборлож болох уурхайн хил хязгаар дотор орших, хаягдал, бохирдлыг тооцоолсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг батлагдсан (A'), магадласан (B') үйлдвэрлэлийн нөөц тооцсон байна;

22.6.6.техник, эдийн засгийн үндэслэл нь олборлолтын бэлтгэл үе шатны ажлаас уурхайн хаалт дуусах хүртэлх уул уурхайн төслийн бүх үе шатыг хамруулсан байна;

22.6.7.ашигт малтмалын баяжуулах технологийн туршилтыг **эрх бүхий** мэргэжлийн байгууллагаар хийлгэж тайланг хавсаргасан байна;

22.6.8.төслийн мэдрэмжийн болон эрсдлийн шинжилгээг бүтээгдэхүүний үнэ, валютын ханш, хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал, борлуулалтын хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр тооцсон байна.

22.7.Энэ хуулийн 22.6-д зааснаар ирүүлсэн тайлан, материалын бүрдэл бүрэн бус, мөрдөж буй заавар, журмын шаардлагыг хангаагүй, танилцах болон хэлэлцэх явцад буцаахаар шийдвэрлэсэн тайлан, материалд нэмэлт засвар, тодотгол хийлгэх, эсхүл уг тайлан, материалыг дахин шинээр боловсруулах хугацааг тогтоох, хэлэлцэх тайлан, материалтай холбогдсон нэмэлт тайлбар, мэдээллийг холбогдох байгууллага, аж ахуй нэгжээр гаргуулна.

22.8.Техник, эдийн засгийн үндэслэлийн шинжээч нь уул уурхайн салбарын мэргэжлийн зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй, тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг, мэргэжлийн болон ёс зүйн зөрчилгүй зэрэг шаардлагыг хангасан байна.

22.9.Зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй техник, эдийн засгийн үндэслэл боловсруулагч болон шинжээч нь өөрийн бие дааж болон удирдан техник, эдийн засгийн үндэслэл, төсөл, хянаж баталгаажуулсан ажлын үр дүн, түүний чанарыг бүрэн хариуцна.

23 дугаар зүйл. Техник, эдийн засгийн үндэслэлийг хадгалах, ашиглах ба шинэчлэн боловсруулах

23.1.Техник, эдийн засгийн үндэслэлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тус бүр гурван хувь үйлдсэн байх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч, төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжид тус тус нэг хувийг хадгална.

23.2.Төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийн хэвлэмэл болон цахим хувилбарыг ордын ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ашиглана.

23.3.Төсөл хэрэгжүүлэгч нь дараах тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх, тодотгох үүргийг хүлээнэ.

23.3.1.хөрөнгө оруулалтын хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүйгээс уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эхлээгүй эсхүл төслийн хүчин чадалд хүрэлгүй 5 жил болсон;

23.3.2.үйлдвэрлэлийн хүчин чадлыг 30-аас дээш хувиар өөрчлөх шаардлага бий болсон;

23.3.3.бүтээгдэхүүний зах зээлийн үнэ 25%-иас илүүтэй өөрчлөгдсөн;

23.3.4.ашиглагдаж буй техник, технологи өөрчлөгдсөний улмаас ашиглалтын систем, технологийн схем өөрчлөгдөх болсон;

23.3.5.ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд болон тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авснаас хойш 5 жил өнгөрсөн.

23.4.Төсөл хэрэгжүүлэгч нь техник, эдийн засгийн үндэслэлийн хэрэгжилтийг хангахдаа жил бүрийн тайлан, уулын ажлын төлөвлөгөөгөөр баталгаажуулна.

23.5.Ашиглалтын явцад техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан захын агуулга, жишиг үзүүлэлтүүд, нөөц зэрэг голлох үзүүлэлтэд бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ханшийн хэлбэлзэл, үйлдвэрлэлийн зардлын өөрчлөлт зэргээс шалтгаалан гарах бага хэмжээний эдийн засгийн өөрчлөлтийг төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн эцэст шинэчлэн тогтоож, дараа жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусган төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжид мэдэгдэнэ.

24 дүгээр зүйл. Техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээж авах

24.1.Энэ хуулийн 6.1.1-д заасан улсын хэмжээний буюу эрсдэл ихтэй уурхай болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг захиапж хийлгэсэн төсөл хэрэгжүүлэгч нь түүний хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийсэн тус бүр нэг хувийг төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжид хүргүүлэх бөгөөд тус нэгж нь санал, дүгнэлтээ гарган Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлнэ.

24.2.Энэ хуулийн 6.1.2-д заасан бүс нутгийн хэмжээний буюу дунд зэргийн эрсдэлтэй, мөн хуулийн 6.1.3-д заасан орон нутгийн хэмжээний буюу эрсдэл багатай уурхай болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг захиапж хийлгэсэн төсөл хэрэгжүүлэгч нь түүний хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийсэн тус бүр нэг хувийг төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжид хүргүүлэх бөгөөд тус нэгж нь санал, дүгнэлтээ гарган төрийн захиргааны байгууллагын даргад хүргүүлнэ.

24.3.Энэ хуулийн 24.1-д заасан техник, эдийн засгийн үндэслэлд шинжээчийн баг, мөн хуулийн 24.2-т заасан техник, эдийн засгийн үндэслэлд шинжээч томилон шинжээчийн дүгнэлт гаргуулна.

24.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 6.1.1-д заасан улсын хэмжээний буюу эрсдэл ихтэй уурхай болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр техник-эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.

24.5. Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 6.1.2-д заасан бүс нутгийн хэмжээний буюу дунд зэргийн эрсдэлтэй, мөн хуулийн 6.1.3-д заасан орон

нутгийн хэмжээний буюу эрсдэл багатай уурхай болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 30 хоногт багтаан байгууллагынхаа холбогдох нэгжээр дүгнэлт гаргуулсны үндсэн дээр техник-эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.

24.6.Стратегийн ач холбогдол бүхий орд газрыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн шинжээчийн багийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар томилон ажиллуулна.

24.7.Шинжээч ба төсөл захиалагчийн аль нэг нь шинжээчийн дүгнэлт гаргах талаар татгалзсан бол шинжээчтэй холбоотой асуудлыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд дахин нэг удаа санал гаргах боломжтой.

24.8.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралд техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлэхээс өмнө төсөл боловсруулагч шинжээчийн дүгнэлтэд хариу өгч шинжээч өгсөн хариуг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг баталгаажуулсан байна.

24.9.Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд төсөл боловсруулагч байгууллага танилцуулах бөгөөд зөвлөлийн гишүүдийн асуултад төсөл боловсруулагч, төсөл захиалагч албан ёсоор хариулт өгнө.

25 дугаар зүйл. Далд уурхайн зураг төсөлд тавигдах шаардлага

25.1.Далд уурхайн зураг төслийг тэдгээрийг барихаар төлөвлөж байгаа талбайн геологийн, геофизикийн, геотехникийн, гидрогеологийн болон бусад судалгааны материалыг үндэслэн зохионо.

25.2.Далд уурхайн зураг төслийг гагцхүү ашигт малтмалын нөөцийг нь тогтоож, ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг нь хэлэлцэж шийдвэрлэсний дараа зохионо.

25.3. Далд уурхайн зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн байршлыг тэдгээрийн зураг төслийн ажил эхлэхээс өмнө зохих нутгийн захиргааны байгууллага, төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагатай тохиролцоно.

26 дугаар зүйл. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төсөл зохиоход тавих үндсэн шаардлага

26.1.Далд уурхайн зураг төсөлд дор дурдсан үндсэн шаардлагыг тусгасан байвал зохино:

26.1.1.газар дээрх болон доорхи үйлдвэрийн газрын барилга байгууламжийн байршлыг ашигт малтмалын нөөцийг үр ашигтай, зөв зохистой ашиглах шаардлагад нийцүүлэн тогтоох;

26.1.2.үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмалын нөөц, тэдгээрт байгаа үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг газрын хэвлийгээс эдийн засгийн хувьд илүү зохистой, гүйцэд гаргаж авах шаардлагыг хангахуйц ашигт малтмалын ордын нөөцийг олборлохоор нээх арга, ашиглах системийг сонгож тогтоох;

26.1.3.ашигт малтмал олборлох тэргүүний техник технологийг нэвтрүүлэх;

26.1.4.уулын малталтын чулуулгийг зөв зохистой ашиглах;

26.1.5.үйлдвэрлэлийн явцад дайвраар олборлосон бөгөөд ашиглаагүй байгаа ашигт малтмал, түүнчлэн ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэн авч хадгалж хамгаалах;

26.1.6.ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг барих, ашиглах явцад газрын хэвлийд геологийн судалгаа хийж геологи, маркшейдерийн баримт бичгийг бүрдүүлэх;

26.1.7.хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлийн болон байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах.

27 дугаар зүйл. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ

27.1.Тогтоосон цаг хугацаанд тухайн ашигт малтмалын үнэ цэнийг мөнгөн дүнгээр илэрхийлэн тооцох зорилгоор ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хийнэ.

27.2.Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг ашигт малтмалын ордыг хөрөнгийн биржид гаргаж хөрөнгө босгох, мөн ордын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, хөрөнгийн үнэлгээтэй холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж болно.

28 дугаар зүйл. Үнэлгээчинд тавигдах шаардлага

28.1.Үнэлгээчин нь үнэлж байгаа тухайн ашигт малтмалын хөрөнгийн талаар мэргэшсэн, чадамжтай, тайлагнах ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний талаар 5 жилээс багагүй жил ажилласан ажлын туршлагатай байх ёстой.

28.2.Хэрвээ үнэлгээчин нь үнэлгээний тайлангийн зарим хэсгийг бэлтгэх чадамжгүй бол, энэхүү хэсэгт холбогдох тохирох боловсрол, чадамжтай, мэргэшсэн этгээдийг ажиллуулж болно.

28.3.Мэргэшсэн этгээд нь холбогдох техникийн үнэлгээ хийх талаар 5 жилийн туршлагатай, ашигт малтмалын үнэлгээ хийх тохиолдолд, тухайн ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний талаар 5 жилийн ажлын туршлагатай (нийт 10 жил) байна.

29 дүгээр зүйл. Үнэлгээчний үүрэг хариуцлага

29.1.Үнэлгээчин нь үнэлгээ хийх хариуцлага болон үнэлгээний тайланд тусгагдсан нийт үр дүнд дараах хариуцлагыг хүлээнэ.

29.1.1.үнэлгээ хийх хандлага болон аргыг сонгоно;

29.1.2.техникийн мэдээлэл, тайлантай танилцах, үнэлгээ хийхэд туслан оролцсон аливаа шинжээч, мэргэшсэн этгээд нь зохих түвшинд мэргэшсэн, туршлагатай болохыг баталгаажуулах, шинжээчдийн оролцоог үнэлгээний тайланд тайлагнан үзүүлэх, шинжээчдийн зүгээс үнэлгээний тайланд хэрхэн оролцсоноо өөрсдөө баталгаажуулсан баримтыг тайланд хавсаргана;

29.1.3.энэхүү удирдамжийн загварын шаардлагууд болон бусад холбогдох зарчмуудыг дагаж мөрдөнө;

29.1.4.ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд ашигласан техникийн мэдээлэл, түүний тайлбар, үнэлэлт дүгнэлт, урьдчилсан таамаглал, өгөгдөл, урьдчилсан тооцоо, үзүүлэлтийн үндэслэлтэй, үнэн зөв байдлыг тогтооно;

29.1.5.ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх болон үнэлгээний тайланд тавигдах Монгол Улсын хууль, эрх зүйн болон холбогдох бусад шаардлагыг дагаж мөрдөнө;

29.1.6.үнэлгээ ба үнэлгээний тайланг бүхэлд нь хариуцаж байгаагаа батлан үнэлгээний тайланд гарын үсэг зурна.

30 дугаар зүйл. Үнэлгээний тайлан

30.1.Үнэлгээний тайлан олон нийтэд нээлттэй байх эсэхээс үл хамааран доор хаяж дараах мэдээллийг заавал оруулна:

30.1.1.ашигт малтмалын хөрөнгийн тодорхойлолт;

30.1.2.зориулалтын хэрэглээ болон зориулагдсан хэрэглэгчид, үнэлгээний хэрэглээ болон түүний олон нийтэд түгээх хязгаарлалтууд;

30.1.3.үнэлгээний зорилго;

30.1.4.үнэ цэнийн үндэслэл;

30.1.5.тайлангийн огноо, үнэлгээний хугацаа;

30.1.6.үнэлгээний хугацаан дахь хамгийн өндөр өгөөж, хамгийн сайн ашиглалтын тодорхойлолт;

30.1.7.хийх ажлын цар хүрээ;

30.1.8.үнэлж буй ашигт малтмалын хөрөнгийн геологийн ажлын тайлбар, үнэлгээний хугацаа дахь хайгуул, бүтээн байгуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл;

30.1.9.үнэлгээнд ашигласан өгөгдөл, урьдчилсан таамаглал болон тэдний эрсдэл, хязгаарлалт;

30.1.10.хэрэглэсэн үнэлгээний хандлага, арга болон гарган авсан үнэ цэнийн тооцоолол;

30.1.11.хандлага, аргаас гарсан үнэ цэнийн нэгтгэсэн тохируулга;

30.1.12.үнэ цэнийн санал;

30.1.13.тухайн ашигт малтмалын хөрөнгөнд үнэлгээ хийхээс өмнөх гурван жилийн хугацаанд үнэлгээ хийгдсэн бол тэдгээр үнэлгээнүүдийн үнэ цэнийг хамрагдсан хугацаатай нь тайлагнаж хэрэв бодит материаллаг ялгаа байвал тайлбарлана. Гурван жилээс өмнөх хугацаанд хийгдсэн үнэлгээний тухай мэдээллийг үнэлгээний тайланд тусгах эсэхийг үнэлгээчин нь өөрөө шийднэ;

30.1.14.баттай эсэхийг шалгаж баталгаажуулсан эсэхээс үл хамааран бүхий л өгөгдөл, мэдээлэл, мэдэгдэл тоо баримт, тэдний эх үүсвэр;

30.1.15.ашигт малтмалын хөрөнгийн байршил дээр очиж танилцсан эсэх тухай мэдэгдэл;

30.1.16.үнэлгээ хийхэд тухайн улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код буюу стандартыг дагаж мөрдсөн тухай мэдэгдэл. Хэрэв дагаж мөрдөгдөөгүй ямар нэг зөрчил байгаа бол энэ талаархи мэдэгдэл;

30.1.17.үнэлгээчин, шинжээчдийн овог нэр, мэргэшил, туршлага, тайлангийн аль хэсгийг хариуцан ажилласан тухай мэдэгдэл;

30.1.18.үнэлгээчин, шинжээч нарын бие даасан, эсвэл хараат байдлын талаархи мэдэгдэл;

30.1.19.үнэлгээчний гарын үсэг зурж баталгаажуулсан мэргэшсэн, чадамжтай байдлын мэдэгдэл, түүнчлэн үнэлж буй ашигт малтмалын хөрөнгөтэй ямар нэгэн ашиг сонирхолын зөрчилгүй эсвэл болзошгүй ашиг сонирхлын талаарх мэдэгдэл, хөрөнгийг байршил дээр нь очиж шалгасан бол огноог тусгана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Ашигт малтмал ашиглах, баяжуулах, боловсруулахын өмнөх үйл ажиллагаа

31 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага

31.1.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу авч ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа явуулна.

31.2.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлүүлсэн байна.

31.3.Баяжуулах, боловсруулах эрх, тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуулийн шаардлагад нийцүүлэн авсан байна.

31.4.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан байна.

31.5.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлүүлсэн техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

31.6.Энэ хуулийн 31.2, 31.4, 31.5-д заасан баримт бичгүүд нь хоорондоо нягт учлдаатай бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө нэгдсэн байдлаар шийдвэрлүүлнэ.

31.7.Техник, эдийн засгийн үндэслэл болон хаалтын төлөвлөгөөгөөр уурхай байгуулах, овоолго үүсгэх, дэд бүтэц, үйлдвэрлэлийн болон ахуйн барилга байгууламж барьж байгуулах, нөхөн сэргээлт, хаалтын үед болон хаалтын дараа ашиглагдах зориулалт бүхий байгууламж зэргийг багтаасан ерөнхий дэвсгэр зургийг үйлдэж тэдгээрт шаардагдах талбайн хилийн булангийн цэгүүдийн солбицлыг хэмжиж тусгай зөвшөөрлийн дэвсгэр зурагт буулгасан байна.

32 дугаар зүйл.Уурхай, уулын үйлдвэрийн жил бүрийн ажлын төлөвлөгөө

32.1.Уурхай, уулын үйлдвэрийн уулын ажлын төлөвлөгөөг ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тулгуурлан жил бүр Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.2-д заасан хугацаанд мөн хуулийн 48.11-д заасан маягтын дагуу боловсруулна.

32.2.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь дараагийн жилд уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахгүй бол энэ тухайгаа төрийн захиргааны байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

32.3.Уулын ажлын төлөвлөгөө нь уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаанд тухайн жилд заавал мөрдөх баримт бичиг болно.

32.4.Уулын ажлын төлөвлөгөө нь дараах агуулгатай байна:

32.4.1.уулын ажил төлөвлөж буй улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөц, нөөцийн дэвсгэр зураг, геологи, маркшейдерийн хэмжилт хийсэн уулын ажлын дэвсгэр зураг;

32.4.2.ашигт малтмалын хаягдал, бохирдлын тооцоо, ашиглах үндсэн нөөц;

32.4.3.хөрс хуулалт, нэвтрэлт, олборлолт, овоолго, баяжуулалтын технологи, тэдгээрийн хэмжээ, үндсэн тоног төхөөрөмж;

32.4.4.технологийн туршилтын үр дүн;

32.4.5.хүдэр, элс, бүтээгдэхүүн олборлолтын хэмжээ, агуулга;

32.4.6.цахилгаан, усан хангамж, бусад дэд бүтцийн бүрдүүлэлт;

32.4.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохицуулалт;

32.4.8.байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаа;

32.4.9.уурхай, уулын үйлдвэрийн бүтэц зохион байгуулалт, хүний нөөц;

32.4.10.бүтээгдэхүүн борлуулалт, татвар, төлбөр, хураамж төлөлт, эдийн засгийн үр ашгийн тооцоо.

32.5. Уулын ажлын төлөвлөгөөнд дараах баримтыг хавсаргасан байна:

32.5.1.Уул уурхайн аврах албаар хянуулсан аюул устгах төлөвлөгөө;

32.5.2.хаалтын төлөвлөгөөний тухайн жилийн тодотгол, нэмэлт, өөрчлөлтийн санхүүгийн барьцааны мэдээлэл;

32.5.3.хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээл, хувьцаа эзэмшигчийн холбоотой хийхээр төлөвлөж буй үйл ажиллганы талаарх мэдээлэл;

32.5.4.бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн талаархи мэдээлэл болон бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний талаархи мэдээлэл.

32.6.Уулын ажлын төлөвлөгөөтэй хамт байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

33 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагаа

33.1.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь шаардлагатай гэж үзвэл Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан нөхцлөөр Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно.

33.2.Ашигт малтмалын тухай хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон болон стратегийн ач холбогдол бүхий ордод төрийн эзэмшлийн хувь хэмжээ, стратегийн ач холбогдол бүхий ордын нөөц ашигласны төлбөрийн асуудлаар орд ашиглах гэрээ байгуулна.

33.3.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэсэн байна.

33.4.Дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгож хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн бол энэ тухай төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

33.5.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагааг эхүүлэхийн өмнө ордыг ашиглах болон үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан дэд бүтцийг бүрдүүлнэ.

33.6.Энэ хуулийн 33.5-д заасан дэд бүтцийн хүчин чадалтай уялдуулан уурхай, уулын үйлдвэрийн барилга байгууламжийг барьж байгуулна.

33.7.Уурхай, уулын үйлдвэрийн барилга байгууламж нь энэ хууль болон Барилгын тухай хуульд заасан шаардлагын дагуу зураг төсөл нь зохиогдож баригдсан байна.

33.8.Баригдсан барилга байгууламжийг Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу ашиглалтад оруулна.

33.9.Ашигт малтмалыг олборлон баяжуулах, боловсруулах тохиолдолд хагас үйлдвэрлэлийн туршилт явуулж үр дүнгийн тайланг баталгаажуулан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

33.10.Хайгуулын ажлын дүнгийн тайлан боловсруулах үед хийлгэсэн технологийн туршилтын тайлан нь ордыг төлөөлөх хэмжээний дээжид үндэслэн баяжуулалтын технологийг оновчтой сонгосон байвал хагас үйлдвэрлэлийн туршилт хийхгүй байж болно.

33.11.Уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд газар ашиглах, ус ашиглах болон холбогдох бусад зөвшөөрлийг авч гэрээ байгуулсан байна.

33.12.Уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулахтай холбогдуулан нийгэм, эдийн засгийн үнэлгээ хийлгэж орон нутгийн иргэд, олон нийтийн байгууллагад танилцуулж зөвшилцсөн байна.

33.13.Уурхайг ашиглалтад оруулахын өмнө хөрс хуулалт, далд уурхайн бэлтгэл малталтуудыг гүйцэтгэн хүдэр, элс, бүтээгдэхүүн гаргах бэлтгэл ажлыг хангасан байна.

33.14.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө инженер, техникийн ажилтан, ажиллагсдын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

33.15.Төслийн ус шүүрүүлэх, зайлуулах систем, агааржуулалт, төсөлд шаардагдах бодис урвалж, хаягдлын аж ахуй, тэсрэх материал зэрэгтэй холбоотой зөвшөөрлүүдийг эрх бүхий байгууллагуудаас авна.

33.16.Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээг төсөл хэрэгжих нийт хугацаанд болон техник, эдийн засгийн үндэслэл, уурхайн хаалтын төлөвлөгөө тодотгох бүрт нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтойгоор байгуулна.

33.17.Зах зээлийн судалгаанд тулгуурлан бүтээгдэхүүн борлуулах, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээг байгуулна.

33.18.Уурхайн үндсэн болон туслах процессууд, гадаад тээврийн ажлуудыг гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээдүүдтэй ажил гүйцэтгэх гэрээг байгуулна.

33.19.Уурхайн барилга, байгууламж барих талбай, овоолго, хаягдлын талбайг сонгож байршуулахын өмнө уг талбайд геотехникийн судалгаа хийж, ашигт малтмалын нөөц, илэрц байгаа эсэхийг тодорхойлсон байна.

34 дүгээр зүйл.Уурхай, уулын үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулах

34.1.Энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан бэлтгэл ажлыг ханган олборлолтын бэлтгэл үе шат дуусч уурхайг байнгын ашиглалтанд оруулахад бэлэн болсон гэж үзвэл төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган тус

байгууллага уурхай, уулын үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулах Улсын комиссыг ажиллуулна.

34.2.Уурхай, уулын үйлдвэрт техник, технологийн шинэчлэлт хийж ашиглалтын систем, технологийн схемд өөрчлөлт оруулсан, хүчин чадлаа 30-аас дээш хувиар нэмэгдүүлэх техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж түүний дагуу өргөтгөсөн, Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-д заасан хугацаанаас хойш үйл ажиллагаагаа эхлүүлэлгүй 5 жилийн хугацаа өнгөрсөн, уурхай түр хаалтын горимоос ашиглалтын горимд шилжих болсон тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагад дахин хандаж Улсын комиссыг ажиллуулна.

34.3.Улсын комиссыг төрийн захиргааны төв байгууллага ахлан зохион байгуулах бөгөөд комиссын бүрэлдэхүүнд төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, шаардлагатай гэж үзвэл нутгийн захиргааны байгууллагын төлөөллийг оруулна.

34.4.Стратегийн ач холбогдол бүхий томоохон ордын уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулахад Засгийн газрын шийдвэрээр комисс томилж ажиллуулж болно.

34.5.Комисс акт үйлдэгдэж комиссын гишүүдийн гарын үсэг зурагдаж баталгаажсанаар уурхай, уулын үйлдвэр байнгын ашиглалтад оруулж үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа

35 дугаар зүйл.Олборлолтын үйл ажиллагаа

35.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 34.5-д заасны дагуу үйл ажиллагаагаа эхэлж бүтээгдэхүүн борлуулах эрх нээгдэнэ.

35.2.Төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 24.5-д заасны дагуу хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэл, төрийн захиргааны байгууллагын хүлээн авсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг явуулна.

35.3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлолтын үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлд тусгаснаас зөрүүтэйгээр явуулах бол тэрхүү шалтгааныг уулын ажлын төлөвлөгөөнд тодорхой тусган, зөрүүгийн хэмжээг энэ хуулийн 34.2-т зааснаас хэтрүүлэхгүйгээр тооцож төлөвлөж болно.

35.4.Олборлолтын үйл ажиллагааны үед уулын үндсэн болон туслах

процессуудыг салбарын хэмжээнд мөрдөгдөх хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг баримтлан сонгосон ашиглалтын технологийн дагуу явуулна.

35.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагааны үед төрийн захиргааны байгууллагад мэдээлэл ирүүлж байх үүрэг бүхий ажилтныг томилж тэрхүү ажилтан нь дараах мэдээллийг тогтмол ирүүлж байна:

35.5.1.долоо хоног бүр борлуулсан болон борлуулахаар ачуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, үнийн мэдээлэл;

35.5.2.сар бүрийн борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, үнэ, худалдан авагч, уурхай дээрх болон хилийн боомт дээрхи агуулахад байгаа бүтээгдэхүүний хэмжээний талаарх мэдээлэл;

35.5.3.уурхайн бүс нутагт байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл, авар, осол гарсан тохиолдолд тухай бүрт энэ тухай;

35.5.4.олборлолтын үйл ажиллагаатай болон хөрөнгө оруулагч, зах зээл, боомт, тээвэрлэлттэй холбоотой гарсан гэнэтийн өөрчлөлтүүд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн холбогдолтой бусад мэдээллийг төрийн захиргааны байгууллагаас шаардсан тухай бүрт.

35.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагааны үе шатуудад ерөнхий болон туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийг авч ажиллуулах тохиолдол бүрт тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, түүнд шаардагдах зөвшөөрөл, ажиллах мэргэжилтэй хүний нөөц болон ажиллагсдын талаарх мэдээлэл, хийх ажлын хэмжээ, хугацааны талаархи мэдээллийг гаргаж төрийн захиргааны байгууллагад ирүүлж байна.

35.7.Уурхайн уулын ажлын ахилтаар нөөцийн блок нээгдэхээс дуусах хүртэлх хугацаанд маркшейдерийн хэмжилт, блокийн ул, хананы дээжлэлтийг хийж нөхцлийг фото зураг авалтаар баримтжуулж тэдгээрт тулгуурлан блок нээсэн, хаасан акт үйлдэж түүнийгээ уулын ажлын тайланд тухай бүр хавсаргаж байна.

35.8.Тухайн олборлолт явуулж буй нөөцийн блокийн үзүүлэлтүүд нөөцийн тайланд тусгагдсанаас зөрөх тохиолдол бүрт нөөц батлагдахгүй байх шалтгааны талаарх тайлбарыг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

35.9.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 35.8-д заасан тайлбар, хавсаргасан нотлох баримтууд хангалтгүй, зөрүүтэй, тооцооны алдаатай байна гэж үзсэн тохиолдолд мэргэшсэн маркшейдер, итгэмжлэгдсэн лаборатори болон өөрийн байгууллагын холбогдох мэргэжилтнүүдийг томилон ажиллуулж дүгнэлт гаргуулна.

35.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нөөцийн блок нээх, хаах, бүтээгдэхүүн борлуулахаар ачуулах тохиолдол бүрт мөн хаягдлын овоолго, хаягдлын далан, түр

агуулах, уурхайн ажлын бус хажууд үлдэх хүдрийн биетийн гадаргаас дээж авч хөндлөнгийн магадлан итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлэн түүний хариуг уулын ажлын тайланд хавсаргаж байна.

35.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын болон баяжуулалтын үеийн хаягдлын овоолго, хоосон чулуулгийн буюу хөрсний овоолго, ядуу хүдрийн овоолгыг холихгүйгээр агуулгаар нь ангилан тус тусад нь үүсгэнэ.

35.12.Өрөмдлөг, тэсэлгээний ажлыг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 15-р зүйлийн шаардлагыг хангасан хуулийн этгээд тухайн ордын уул геологийн нөхцлийг тооцсон паспорт боловсруулж, тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг баримтлан явуулна.

35.13.Олборлолт, ачилт, дотоод тээвэрлэлтийн ажлыг уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх эрхтэй хуулийн этгээд батлагдсан журам, дүрэм, заавар, аргачиллын дагуу явуулна.

35.14.Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон туслан гүйцэтгэгч хуулийн этгээд нь гадаад тээвэрлэлтийг эрх бүхий байгууллагын баталсан маршрутын дагуу хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр гүйцэтгэнэ.

35.15.Хөрсний болон шимт хөрсний овоолгыг батлагдсан стандартын дагуу үүсгэнэ.

35.16.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа Ашигт малтмалын тухай хуулийн 35.5-ыг баримтлан ажиллана.

35.17.Уурхайн хаягдал, бохирдлын хэмжээг уулын ажлын тайланд тусгаж ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, балансыг жил бүр энэ хуулийн 21.2-т заасны дагуу гаргаж төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байна.

35.18.Тухайн жилийн ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, балансыг хуулийн хугацаанд баталгаажуулсны дараа дараагийн жилийн уулын ажлын төлөвлөгөөний асуудлыг төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

35.19.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 35.5-д заасан үүргийг хэрэгжүүлж ажиллана.

36 дугаар зүйл. Үүсмэл ордыг ашиглах

36.1.Үүсмэл ордод Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.27-д зааснаас гадна баяжуулалтын хаягдал, баяжуулах үйлдвэрийн хаягдлын санд бий болсон эрдсийн хуримтлал, хамгаалалтын цул, орхигдсон блокийг үүсмэл ордод хамруулна.

36.2.Үүсмэл ордыг түүний тусгай зөвшөөрлийг эзэмшигч болон түүнтэй

байгуулсан гэрээний үндсэн дээр бусад хуулийн этгээд ашиглаж болно.

36.3.Үүсмэл ордыг ашиглахдаа Ашигт малтмалын тухай хууль болон энэ хуульд заасан үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж ажиллана.

36.4.Үүсмэл ордын нөөцийг уг ордыг үүсгэсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээлэлд үндэслэн тодорхойлохоос гадна ордод хийсэн маркшейдерийн хэмжилт, ордоос дээж авч тодорхойлсон агуулгыг үндэслэн тогтооно.

36.5.Үүсмэл ордыг ашиглахын өмнө технологийн туршилт хийлгэсэн байна.

36.6.Үүсмэл ордын ашигт малтмалыг гидрометаллургийн технологиор боловсруулалт хийх тохиолдолд тусгайлан талбай бэлдэн зориулалтын хулдаас дэвсэж хөрсөнд химийн бодис нэвчих, алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

36.7.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 10 дугаар бүлэгт заасны дагуу төслийн хаалтын талаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

36.8.Үүсмэл ордыг ашиглагч нь Ашигт малтмалын тухай хуулийн 47/3-т заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлнө.

36.9.Үүсмэл ордыг ашиглагч нь тухайн жилд хийсэн ажлын тайлангаа төрийн захиргааны байгууллагад дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

36.10.Үүсмэл ордыг ашиглагч нь энэ хуулийн 35.18-д заасан үүргийг хүлээнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Ашигт малтмалын баяжуулалт, боловсруулалтын үйл ажиллагаа

37 дугаар зүйл. Ашигт малтмалын баяжуулалт, боловсруулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага

37.1.Баяжуулах, боловсруулах үйлдвэр нь холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг баримтлан үйл ажиллагаагаа явуулна.

37.2.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд хаалтын төлөвлөгөөг тусган боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна.

37.3.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн барилга, байгууламжийн зураг төслийг энэ хуулийн 4 дүгээр бүлэг болон Барилгын тухай хуульд заасан

шаардлагад нийцүүлэн боловсруулж Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу **магадлал** хийлгэсэн байна.

37.4.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх магадлан итгэмжлэлийг олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн төрийн бус байгууллага олгоно.

37.5.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийг зураг төслийн дагуу барьж байгуулан ашиглалтад оруулсны дараа төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон улсын комисст хүлээлгэн өгч үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

37.6.Эрдэс түүхий эдийг баяжуулах, боловсруулах үйл ажиллагаанд дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

37.6.1.баяжуулах, боловсруулах үйлдвэрт оруулж байгаа эрдэс түүхий эдийн гарал үүслийг тодорхойлсон байх

37.6.2.эрдэс түүхий эдэд байгаа ашигтай бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн ялган авах технологи хэрэглэх;

37.6.3.эрдэс түүхий эдийн ашигтай бүрэлдэхүүн хэсгийн ялгарцын түвшин, хэмжээг боловсруулалтын шат бүрт бүртгэж, хяналт тавьж байх;

37.6.4.эрдэс түүхий эдийн найрлага, технологийн шинж чанарыг судлан, боловсруулалтын технологийг боловсронгуй болгох;

37.6.5.эрдэс түүхий эдийг баяжуулах, боловсруулахад гарсан хаягдлыг дахин ашиглах асуудлыг судалж үзэх;

37.6.6.ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэн тооцож хамгаалж байх.

37.7.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, эрүүл ахуйн стандартад нийцүүлэн явуулна.

37.8.Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь төрийн захиргааны төв байгууллагад боловсруулалт, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээллийг батлагдсан журмын дагуу, тогтоосон хугацаанд тогтмол ирүүлж байна.

37.9.Баяжуулах, боловсруулах үйлдвэрт өргөтгөл хийсэн тохиолдолд энэ хуулийн **37.5**-д заасан улсын комиссыг дахин ажиллуулна.

37.10.Энэ хуулийн 37.5, 37.9-д заасан комисс ажиллуулахын өмнө хаягдлын усан сангийн далан, ил талбайд овоолгын аргаар уусгах байгууламжийг ашиглалтад оруулах тухай Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын **шийдвэр, акт**, Онцгой Байдлын Газрын дүгнэлт гаргуулсан байна.

38 дугаар зүйл. Ашигт малтмалын баяжуулалт, боловсруулалтын технологи, тоног төхөөрөмж

38.1.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн сонгосон технологи нь тухайн үйлдвэрт ашиглах түүхий эдэд тохирох эсэх талаар мэргэшсэн мэргэжилтнээр дүгнэлт гаргуулна.

38.2.Баяжуулах, боловсруулах үйлдвэрт энэ хуулийн 38.1-д заасан технологид сонгосон тоног төхөөрөмж нь нийцэж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн туршилтын үр дүнгээр баталгаажуулсан байна.

38.3.Баяжуулах, боловсруулах үйлдвэрт ашиглаж байгаа даралтат сав, ачаа өргөх, тээвэрлэх машин, өндөрт температурт ажиллах төхөөрөмж, химийн бодис бэлтгэх, ашиглах төхөөрөмжүүдийг улсын болон хяналтын байгууллагад бүртгэлд авч туршилт, магадлалыг гүйцэтгэж зөвшөөрлийг авсны дараа ашиглалтыг эхлүүлнэ.

39 дүгээр зүйл. Бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний стандарт, чанарт тавигдах шаардлага

39.1.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үндсэн бүтээгдэхүүн нь баяжмал, хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн байна.

39.2.Бүтээгдэхүүний чанарыг стандарт шаардлагаар тодорхойлно.

39.3.Бүтээгдэхүүний стандарт нь MNS болон олон улсын стандартад нийцсэн байна.

39.4.Бүтээгдэхүүний чанарыг төрийн өмчит, гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай итгэмжлэгдсэн лабораторийн үр дүнгээр тодорхойлно.

39.5.Эрдэс түүхий эдийн агуулга, чанарын шинжилгээ, технологийн, хагас үйлдвэрлэлийн туршилтыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, арга аргачлалын дагуу хийлгэх бөгөөд эрх байгууллагаас хүлээн зөвшөөрөөгүй арга, аргачлал хэрэглэхийг хориглоно.

39.6.Эрдэс түүхий эдийн итгэмжлэгдсэн эрх бүхий лаборатори гаргасан үр дүнгийн талаар хуулийн өмнө хариуцна.

40 дүгээр зүйл. Баяжуулалт, боловсруулалтад шаардагдах түүхий эд, урвалж, уусгагч бодисууд

40.1.Аж ахуйн нэгж, байгууллага нь ашигт малтмалыг хуурай, нойтон аргаар баяжуулах, боловсруулах болон уусган баяжуулах үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис ашиглаж байгаа бол тухайн бодисын хор, аюулын шинж

чанар, болзошгүй эрсдлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг хоргүйжүүлэн устгах асуудлыг тусгасан эрсдлийн үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.5-д заасны дагуу заавал хийлгэнэ.

40.2.Химийн хорт болон аюултай бодисыг техникийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд уг тээврийн хэрэгсэлд анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарын тухай санамж байрлуулж тээвэрлэсний дараа тээврийн хэрэгслийг хоргүйжүүлж аюулгүй болгоно.

40.3.Баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь химийн хорт болон аюултай бодистой харьцах ажиллагсдад аюулгүй байдал, болзошгүй осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх зэрэг сургалтыг өөрийн зардлаар зохион байгуулна.

40.4.Химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 14.1-д заасны дагуу устгана.

40.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтад дотоод хяналт тавих ба худалдан авах, хадгалах ажиллагааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн хүрээнд явуулна.

41 дүгээр зүйл. Хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжид тавигдах шаардлага

41.1.Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйн усан сангийн далан, эргэлтийн усан хангамжийн гидротехникийн байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг баримтлах ба барилгын норм ба дүрмийг удирдлага болгоно.

41.2.Хаягдлын аж ахуйн төрөл, хийц, байршлыг сонгож төлөвлөхдөө дараах хүчин зүйлийг тооцсон байх шаардлагатай:

41.2.1.бүс нутгийн газар зүй, байгалийн нөхцөл байдал (өндөршил, хэвгийжил, уур амьсгал, инженер-геологи, гидрогеологи, биологийн нөхцөл байдал болон бусад);

41.2.2.хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө (амьтны аймаг, ургамлын төрөл зүйлийг хадгалах, **экосистемийн** тэнцвэрийг хадгалах);

41.2.3.бэлчээр, тариалангийн талбай, дархан цаазтай газар зэрэг байгалийн нөөц баялаг ашиглалтын тогтсон горимд орох өөрчлөлт;

41.2.4.хүн амын нийгмийн орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө;

41.2.5.ахуйн хэрэглээний болон ундны усны эрүүл ахуйн горимд үзүүлэх нөлөө, азот, фосфор агуулсан бодис зэрэг элементүүдийн агуулгыг тогтоосон хэмжээнд байлгах арга хэмжээ;

41.2.6. байгууламжийг барьж байгуулах болон ашиглалтын бүхий л үе шатны найдвартай ажиллагаа;

41.2.7.далангийн техникийн байдал, байгалийн хүчин зүйлийн нөлөөг тогтмол хянах боломж;

41.2.8.усыг аль болох үр дүнтэй ашиглах, хөрсний усны түвшний тэнцвэрийг хадгалах;

41.2.9.хаягдлын аж ахуйн усан сангийн эргийн хамгаалалт, хашилт, үерийн уснаас хамгаалах суваг шуудууны төлөвлөлт.

41.3.Хаягдлын аж ахуй, овоолгоор уусгах байгууламжийн далан, эргэлтийн усан хангамжийн гидротехникийн байгууламж, тэдгээрийн суурь, хийцийн зураг төслийг гүйцэтгэхдээ барьж байгуулах явцад болон ашиглалтын бүх үед шатуудад ачааллын дээд хязгаарт хүргэхгүй байхаар тооцсон байх ба эрсдэлийг урьдчилан тооцоолж, эвдэрсэн байгууламжийг сэргээх техникийн шийдэл, зааврыг тусгасан байна.

41.4.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь далан хариуцсан мэргэжилтнийг томилж ажиллуулах ба тухайн ажилтан нь хаягдлын аж ахуйн гидротехникийн байгууламжийн ашиглалтын байдалд хяналт тавьж дараах үзүүлэлтийг ашиглалтын зааврын дагуу хянаж, тэмдэглэл хөтөлж, архив үүсгэсэн байна:

41.4.1.усан сангийн усны түвшин;

41.4.2.далангийн суулт;

41.4.3.далангийн шилжилт;

41.4.4.далангийн нэвчилт;

41.4.5.хаялга үүсгэх горим зураг төслийн дагуу мөрдөгдөж байгаа эсэх;

41.4.6.ус цуглуулах худгийн техникийн байдал.

41.5.Үер, газар хөдлөлт зэрэг байгалийн онц аюултай үзэгдэл болсны дараа далангийн байдалд иж бүрэн үзлэгийг зураг төсөлд тусгасан зааврын дагуу гүйцэтгэнэ.

41.6.Хүрээлэн буй орчин, гадаргуугийн болон газрын доорх усыг бохирдохоос хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

41.7.Хаягдлын усан сангаар шүүрлээр гадагшилж байгаа усны химийн найрлагыг гадаргуугийн ус бохирдох хязгаарт байгаа эсэх талаар сар бүр дээжлэлт авч шинжилгээ хийлгэж мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.

41.8.Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Уул уурхайн аврах албаар хянуулан зөвшөөрүүлсэн байна.

41.9.Усан сангийн далангийн ашиглалтын байдал, хаялга бүрдүүлэх байдал, дараагийн шатны өргөтгөлийн суурь үүсгэж байгаа байдалд жилд нэгээс доошгүй удаа зохиогчийн хяналтыг хийлгэнэ.

41.10.Хаягдлын аж ахуйн зураг төсөлд түүнийг ашиглаж дууссаны дараа хаах, дүүрсний дараа түр хадгалах болон тэдгээртэй холбоотой шаардлагатай арга хэмжээнүүдийг тусгасан байна. Мөн зураг төсөлд хаягдлын аж ахуйн эзэлж байсан талбайг нөхөн сэргээх, тохижуулах, талбай, усан санг аж ахуйн зориулалтаар цаашид ашиглах саналууд болон тоосжилтыг арилгах, багасгах, шаардлагатай тохиолдолд хүрээлэн буй орчинд хортой нөлөө үзүүлж болох хаягдалд хуримтлагдсан урвалжуудыг угааж зайлуулах, саармагжуулах арга хэмжээг тодруулгаар заана.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, авран хамгаалах ажиллагааны зохицуулалт

42 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоо

42.1.Уурхай, уулын үйлдвэрийн барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх, ашиглах, хайгуул хийх, олборлох, баяжуулах, боловсруулахтай холбоотой үйл ажиллагаа болон тэдгээртэй холбогдсон бусад ажил гүйцэтгэхдээ аюулгүй байдлын дүрмийг баримтлан ажиллагсдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах шаардлагыг хангасан байвал зохино.

42.2.Ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах улмаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, аюулд өртөх магадлал бүхий эрсдлийг арилгах талаар уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч дараах үүргийг хүлээнэ:

42.2.1.ажиллагсдыг ажлын байранд үйлдвэрлэлийн осолд өртөхгүй байх нөхцлийг бүрдүүлэн байнга сайжруулж байх;

42.2.2.ажиллагсдыг аюул осолд өртөхгүйгээр үүрэгт ажлаа хийхэд зориулсан мэдээ, мэдээллээр хангах, зааварчилгаа өгөх, гүйцэтгэх ажил үүрэгтэй нь холбоотой сургалт явуулж, хяналт тавьж байх;

42.2.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан болон ажиллагсдын ажлын байранд хамт ажилладаг бусад ажилтнуудтай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөлдөн хамтарч ажилладаг байх;

42.2.4.аюулгүй байдлын болон эрүүл ахуйн дүрэм, хэм хэмжээний шаардлагад тохирсон машин техник, тоног төхөөрөмж, материал, ажлын тусгай хувцас, бие хамгаалах бусад хэрэгслээр хангах;

42.2.5.уурхай, уулын үйлдвэрийн ажлын байрыг зориулалтын дагуу бэлтгэн түүний цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, хадгалалт болон үйлдвэрлэлд ашиглаж байгаа химийн бодисыг ашиглах, зөөвөрлөх, боловсруулах, устгах, эмхэлж цэгцлэх, хадгалах ажиллагааг ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөхгүй байхаар зохион байгуулах;

42.2.6.ажиллагсдын амь насанд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, тэднийг аюулгүй газарт гаргаж, уг нөхцөл байдлыг арилгаж хэвийн болгох шаардлагатай арга хэмжээг шуурхай авах;

42.2.7.аюулгүй байдал, эрүүл мэндэд учрах эрсдлийг бууруулах, арилгах үүднээс уурхайн ашиглахаа больсон байгууламжийг тусгаарлах арга хэмжээ авах;

42.2.8.ажиллагсад өртөж болзошгүй бүх төрлийн аюул ослыг илрүүлэх зорилгоор ажлын байранд хяналт, үнэлгээ хийх, тогтмол шалгалт явуулах, осолд өртөж болзошгүй түвшинг тогтоох;

42.2.9.газрын доор ажиллахыг зөвшөөрсөн бүх малталтуудад хангалттай агааржуулалт хийж байх;

42.2.10.тодорхой аюул үүсч болзошгүй бүсэд үйл ажиллагааны тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, ажиллагсдыг хамгаалах арга хэмжээ авах;

42.2.11.ариун цэврийн шаардлага хангагдсан хувцас солих, угаах, хооллох байраар хангах, тэдгээрийг шаардлага хангасан түвшинд тогтмол байлгах үүрэг хүлээх.

42.3.Уурхай, уулын үйлдвэрийн ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь дараах төрөлтэй байна:

42.3.1.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны сургалт;

42.3.2.шинээр ажилд орж байгаа иргэний сургалт;

42.3.3.нийт ажиллагсдын сургалт;

42.3.4.өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалт;

42.3.5.үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтны сургалт;

42.3.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг мэргэжил эзэмшүүлэх болон мэргэшүүлэх сургалт;

42.4. Уурхай, уулын үйлдвэрийн ажиллагсад нь дараах эрх, үүргийг хүлээнэ:

42.4.1.ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүхий л нөхцлөөр хангуулах;

42.4.2.ажил олгогчоос аюулгүй байдал, эрүүл мэндийг нь хамгаалах зорилгоор олгосон хувийн хамгаалах хэрэгсэл, хувцас, тоноглолыг зохих ёсоор ашиглаж аюулгүй байдал, эрүүл мэндээ хамгаалах, тэрчлэн ажлын байран дахь үйлдэл, эс үйлдлийн улмаас бусад хүмүүс хохирч болзошгүй тул тэдгээр хүмүүсийн аюулгүй байдал, эрүүл мэндэд анхаарал тавих;

42.4.3.өөрийн болон бусдын аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл үүссэн бөгөөд энэ нөхцөл байдлыг өөрсдөө зохих ёсоор арилгаж чадахгүй гэж үзсэн тохиолдолд шууд удирдлагадаа даруй мэдэгдэх;

42.4.4.далд уурхайн ажиллагсад нь ээлжийн төгсгөлд ажлын байраа орхин явахдаа ажлын байрны нөхцлийн тухай өөрийнх нь ажилд шууд хяналт тавьдаг ажилтанд, эсхүл тухайн ажлын байрыг нь хүлээн авч байгаа ажилтанд мэдэгдэх;

42.4.5.аюулгүй байдал, эрүүл мэндэд нь ноцтой аюул бий боллоо гэж үзэх хангалттай үндэслэл бүхий нөхцөл үүсвэл байрлалыг орхин гарч аюулгүй байрлалд очих.

43 дүгээр зүйл. Аюулгүй байдлын дүрэм, стандарт

43.1.Уурхай болон уулын үйлдвэрийг ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны бүх хэсэгт аюулгүй байдлын холбогдох дүрмийг чанд мөрдөж ажиллана.

43.2.Энэ хуулийн 8.4-т заасан ил, далд уурхайн болон баяжуулах үйлдвэрийн аюулгүй байдлын дүрэм, тэдгээрийн хэм хэмжээний биелэлтийг хангах үүргийг ажил олгогч хүлээх бөгөөд салбар, нэгж бүрт уг дүрэм, хэм хэмжээний биелэлтэд хяналт тавих ажлыг хариуцсан ажилтантай байна.

43.3.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь дараах шаардлагыг хангасан:

43.3.1.уул уурхайн чиглэлээр баклавраас дээш боловсролын зэрэгтэй, үйлдвэрлэлд 3-аас доошгүй жил ажилласан байна;

43.3.2.энэ хуулийн 40.3.1, 40.3.6-д заасан сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

44 дүгээр зүйл. Авран хамгаалах ажиллагааны зохион байгуулалт

44.1.Төрийн захиргааны төв байгууллага нь ил, далд уурхай, уулын үйлдвэрт тохиолдож болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, түүний үр дагаварыг арилгах, аврах үйл ажиллагаанд оролцох ажиллагсдыг чадавхижуулах үүрэг бүхий Уул уурхайн аврах албатай байна.

44.2.Уурхай, уулын үйлдвэр нь дэргэдээ аврах нэгжтэй байна.

44.2.1.уурхай, уулын үйлдвэрт байвал зохих аврагчид болон аврах тоног төхөөрөмжийг уурхай, үйлдвэрт ажиллаж буй ажиллагсдын тооноос хамааруулан тогтооно.

44.2.1.ил, далд уурхай, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн эрсдлийн түвшин, тохиолдож болзошгүй аюулын зэрэглэлээс хамаарч аврах нэгжийг зохион байгуулна.

44.3.Уурхай болон уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, бичил уурхай эрхлэх зорилгоор зохион байгуулагдсан нөхөрлөл, хоршооны гишүүд энэхүү албаны үйлчилгээнд хамрагдана.

44.4.Уул уурхайн аврах алба нь тохиолдож болзошгүй үйлдвэрлэлийн аюул ослоос урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, аюул ослын холбогдолтой төлөвлөлтэд оролцох, сургалт зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, аюул осол үүссэн үед хүмүүсийг аврах, түүний үр дагаварыг арилгах, аврах нэгжийг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий мэргэжлийн байгууллага байна.

44.5.Уурхай болон уулын үйлдвэрт аюул осол үүссэн үед нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага харъяалал

харгалзахгүйгээр тээврийн хэрэгсэл, материал, тоног төхөөрөмж, эм, эмчилгээний эд зүйл олгох, холбооны хэрэгслээр үйлчлэх, аюул ослын үр дагаварыг арилгахад шаардагдах бүх төрлийн тусламж үзүүлэх үүрэгтэй.

44.6.Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага өөрийн харъяа уурхай, үйлдвэрийн аврах нэгжийн дүрэм, аврах үйл ажиллагааны журмыг Уул уурхайн аврах албаар хянуулж зөвшөөрүүлсэн байна.

44.7.Уул уурхайн аврах албаны ажилтныг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.17-д заасантай дүйцүүлэн ойлгоно.

44.8.Уул уурхайн аврах албаны албан хаагчид тавигдах шаардлага, эрх, үүрэг, албан хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 30, 31, 33, 34 дүгээр зүйлд заасантай дүйцүүлэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Байгаль орчин, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа

45 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгчдийн байгаль орчны талаар хүлээх үүрэг

45.1.Энэ хуулийн 6.1.1-д заасан улсын хэмжээний буюу эрсдэл ихтэй уурхай, уулын үйлдвэр нь байгаль орчныг хамгаалах асуудлыг хариуцсан нэгжтэй байна.

45.2.Энэ хуулийн 6.1.2-т заасан бүс нутгийн хэмжээний буюу дунд зэргийн эрсдэлтэй болон мөн хуулийн 6.1.3-т заасан орон нутгийн хэмжээний буюу эрсдэл багатай уурхай, уулын үйлдвэрт байгаль орчныг хамгаалах мэргэжилтэнтэй байна.

46 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах талаар хүлээх үүрэг

46.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар Ашигт малтмалын тухай хуулийн 39, 40 дүгээр зүйлд заасан үүргийг хүлээнэ.

46.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн удирдлагатай байгаль орчныг нөхөн сэргээх, байгаль орчны чанар байдлыг дүйцүүлэн сайжруулах талаар Хамтран ажиллах гэрээ, Орон нутаг хөгжүүлэх гэрээгээр харилцан тохиролцож болно.

46.3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагаанд өртсөн газарт нөхөн сэргээлтийн ажил хийхдээ тухайн газрыг

ойжуулах арга хэмжээг газар нутгийн бүс харгалзахгүйгээр заавал авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

47 дугаар зүйл. Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгчийн байгаль орчныг хамгаалах талаар хүлээх үүрэг

47.1.Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

47.1.1.эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах;

47.1.2.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тухайн үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;

47.1.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үйлдвэрийн үйл ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах;

47.1.4.байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэ хуулийн 47.1.3-т зааснаас гадна дараахь зүйлийг тусгах:

47.1.4.1.хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих;

47.1.4.2.газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах;

47.1.4.3.уурхайн хаягдлын далан, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах;

47.1.4.4.тухайн үйлдвэрийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон бусад арга хэмжээ.

47.1.5.энэ хуулийн 47.1.1-д заасны дагуу боловсруулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

47.1.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдмагц тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тэдгээрийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг

дэвсгэрийг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

47.1.7.үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлэх бөгөөд уг тайланд дараахь зүйлийг тусгах:

47.1.7.1.байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

47.1.7.2.ашигласан шинэ техник, технологи;

47.1.7.3.үйлдвэрийг өргөтгөж хүчин чадлыг нь нэмэгдүүлсний улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнтэй холбогдуулан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал.

47.1.8.байгаль хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд үйлдвэрийн талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;

47.2.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 47.1.5, 47.1.7.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

47.3.Үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь шинэ техник, технологи нэвтрүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх шинэ нөхцөл, байдал үүсвэл байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

АРАВДУГААР БҮЛЭГ

Бүтээгдэхүүний борлуулалт

48 дугаар зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд борлуулах

48.1.Уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд худалдах, худалдан авахдаа уг бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгоно.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасан гарал үүслийн тодорхойлолтыг уурхай, уулын үйлдвэр эрхлэгч тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан гаргана.

48.3.Уул уурхайн бүтээгдэхүүнийг шаардлагатай тохиолдолд төрийн

байгууллага худалдан авч борлуулж болно.

Монгол Банкинд болон түүнээс эрх олгогдсон байгууллагад зөвхөн алт олборлогч ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч алт тушаах ба аливаа иргэн болон бусад хуулийн этгээд алт тушаах бол тушааж буй алтны гарал үүслийг тодорхойлох бичиг баримтыг тухайн алтыг анх олборлосон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн эзэмшигчээс заавал гаргуулсан байна.

49 дүгээр зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортод гаргах

49.1.Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрдэс баялгийн биржийн тухай тусгай хуулиар зохицуулж болно.

49.2.Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтад олон улсын үнэ ханшийг баримтлана.

49.3.Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкаар дамжуулна

50 дугаар зүйл. Лабораторийн, технологийн туршилтад эрдэс бүтээгдэхүүний дээж экспортод гаргах

50.1.Лабораторийн, технологийн туршилтад зориулан дээж гаргахдаа Энэ хуулийн 9.8-д заасан Ашигт малтмал хил нэвтрүүлэх, экспортлоход дагаж мөрдөх журмыг баримтлана.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

УУРХАЙ, УУЛЫН ҮЙЛДВЭРИЙН ХААЛТ

51 дүгээр зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын зохицуулалт

51.1.Уурхай, уулын үйлдвэрийн хаалтыг хаалтын төлөвлөгөө, хаалтын баталгаа, эрсдэлийн сантай холбоотой харилцаагаар зохицуулна.

51.2.Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь хаалтын төлөвлөгөө, хаалтын баталгааны гэрчилгээгүйгээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

51.3.Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь санхүүгийн баталгааны гэрчилгээ авснаар хаалттай холбоотой үүрэг үүсч, хаалтын гэрчилгээ авснаар уг үүргээс чөлөөлөгдөнө.

51.4.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нарийвчилсан хайгуулын үе шатанд уулын ажил явуулах тохиолдолд хайгуулын ажлын төлөвлөгөөг дагалдуулан хаалтын төлөвлөгөө төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

51.4.1.энэ хуулийн 51.4-т заасан хаалтын төлөвлөгөөг бага эрсдэлтэй уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөтэй дүйцүүлэн шийдвэрлэнэ.

51.5.Хаягдсан уурхайн хүрээнд шинээр тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн этгээд нь тухайн хаягдсан уурхайг хаах асуудлыг хаалтын төлөвлөгөөндөө тусгаж ирүүлэх ба энэ нь тусгай зөвшөөрөл хүссэн этгээдэд давуу эрх олгох үндэслэл болно.

52 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөө

52.1.Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагааны хаалтын төлөвлөгөөг энэхүү хууль, дагалдах журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

52.2.Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь энэ хуулийн 52.9-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагын хүлээн авч шийдвэрлэсэн хаалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг заагдсан хугацаанд шалгуур үзүүлэлтэд хүргэж хэрэгжүүлнэ.

52.3.Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь хаалтын төлөвлөгөөнд материаллаг өөрчлөлт гарсан, эсхүл хаалтын төлөвлөгөө батлуулсанаас хойш 5 жил тутамд тодотгож төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

52.3.1.уурхай, уулын үйлдвэрийг бүрмөсөн хаахаас 1 жилийн өмнө хаалтын төлөвлөгөөг заавал тодотгоно.

52.4.Хаалтын төлөвлөгөө, тодотгол нь олон нийтэд нээлттэй байна.

52.5.Төрийн захиргааны байгууллага нь уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжээс ирүүлсэн уурхайн хаалтын төлөвлөгөөг хүлээн авч энэ хуулийн 13.10.2-т заасан хугацаанд шийдвэр гаргахаас гадна хаалтын төлөвлөгөө нь шаардлага хангаагүй гэж үзвэл буцаах шийдвэр гаргана.

52.6.Төрийн захиргааны байгууллага нь хаалтын төлөвлөгөөг хүлээн авч шийдвэрлэх тохиолдолд дараах агуулга бүхий шийдвэр гаргана:

52.6.1.уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, тусгай зөвшөөрлийн мэдээлэл;

52.6.2.уул уурхайн төсөл хэрэгжих хугацаа;

52.6.3.хаалтын төлөвлөгөөний хүрээнд авах арга хэмжээ, хэрэгжүүлэх ерөнхий хуваарь;

52.6.4.хаалтын төлөвлөгөөгөөр тооцсон зардлын хэмжээ, уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжээр баталгаа гаргуулах тухай шийдвэр;

52.7.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь хаалтын төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагад ирүүлэхээс өмнө олон нийтэд хэлэлцүүлж санал авсан байна.

52.7.1.шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны байгууллага олон нийтийн хэлэлцүүлгийг дахин зохион байгуулж болно.

52.7.Энэ хуулийн 52.6-д заасан шийдвэр нь хаалтын баталгааны баримт бичгийг хавсаргаснаар хүчин төгөлдөр болно.

52.8.Хаалтын үүргээ өмнөх төсөл хэрэгжүүлэх явцад хангалтгүй биелүүлсэн, эсхүл биелүүлээгүй уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж шинэ төсөлд хаалтын төлөвлөгөө ирүүлэх тохиолдолд түүний санхүүгийн баталгааг 40 хувиар нэмэгдүүлж тооцно.

52.9.Хаалтын төлөвлөгөөний биелэлтийг Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3-т заасан тухайн уурхай, уулын үйлдвэрийн жилийн тайланд хавсаргаж төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

53 дугаар зүйл. Уурхайн хаалтын төлөвлөгөөний агуулга

53.1.Хаалтын төлөвлөгөөний агуулга нь дараах шаардлагыг хангасан байна:

53.1.1.уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл;

53.1.2.төсөл хэрэгжих талбайн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн суурь төлөв байдлын үнэлгээ;

53.1.3.нэг буюу хэд хэдэн мэргэшсэн хөндлөнгийн этгээдийн гарын үсэг зурсан, нөөцийн хэмжээ, уурхай, үйлдвэр, дэд бүтэц, бүтээгдэхүүний төрөл зэргийг агуулсан төслийн тодорхойлолт, техникийн тайлан;

53.1.4.төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ;

53.1.5.төслийн үйл ажиллагааны талбайд физик, химийн тогтвортой байдлыг хадгалах, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалахын тулд уул уурхайн компаниас авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

53.1.6.хаалтын төлөвлөгөөний хүрээнд энэ хуулийн 53.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо;

53.1.7.хаалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний үр дүнг хянах, мониторинг хийж тогтвортой үр дүн гарсныг нотлох хүртэлх хугацаанд тэдгээрт шаардагдах зардлын тооцоо;

53.1.8.хаалтын санхүүгийн баталгааны дүн, санал болгож буй хэлбэр;

53.1.9.хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд орон нутаг, олон нийттэй харилцах хөтөлбөр;

53.1.10.шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримт.

54 дүгээр зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын санхүүгийн баталгаа, эрсдлийн сан

54.1.Хаалтын санхүүгийн баталгаа нь уул уурхайн төслийн аль ч үе шатанд уурхай түр буюу бүрмөсөн хаагдах тохиолдолд нөхөн сэргээлт, хаалт, хаалтын дараа хяналт, мониторинг, арчилгаанд шаардагдах зардалд хангалттай хүрэлцэхүйц байна.

54.1.1.энэ хуулийн 54.1-д заасан зардалд нөхөн сэргээлт, хаалтын ажлыг бүхэлд нь хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлэх тохиолдолд гарах бүх зардлыг багтаасан байна.

54.2.Төсөл хэрэгжүүлэгч нь хаалтын үед хийгдэх эцсийн нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ ба зардлыг багасгах зорилгоор нөхөн сэргээлтийг төсөл хэрэгжүүлэх явцад шат дараатайгаар хийж санхүүгийн баталгаа, хаалтын эрсдэлийг бууруулж болно.

54.3.Төсөл хэрэгжүүлэгч нь санхүүгийн баталгааг төрийн захиргааны байгууллагад гаргана.

54.4.Төсөл хэрэгжүүлэгч санхүүгийн баталгааг зөвхөн дараах хэлбэрээс сонгож гаргана:

54.4.1.бэлэн мөнгө;

54.4.2.арилжааны банкны аккредатив;

54.4.3.уурхайн хаалтад зориулан гаргасан тусгай бонд;

54.4.4.дээрхийн хосолсон.

54.5.Хаалтын төлөвлөгөөг тодотгох бүрт зардлыг дахин тооцоолж, санхүүгийн баталгааг шинэчилж болно.

54.6. Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийг бусадтай нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах эрхээ бусдад шилжүүлэх, барьцаалах замаар компанийг өөрчлөн байгуулах тохиолдол бүрт санхүүгийн баталгааг шинэчилнэ.

54.7. Төрийн захиргааны байгууллага нь дэргэдээ уурхайн хаалтын эрсдэлийн сантай байна

54.8. Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь уурхайн үйл ажиллагаанд өртөж буй нэг куб метр уулын цулд нэг төгрөгөөр тооцож энэ хуулийн 54.7-д заасан уурхайн хаалтын эрсдэлийн санд жил бүр хуримтлал төлнө.

54.9. Төрийн захиргааны байгууллага нь эрсдэлд тулгуурлан эрэмбэлэх зарчмаар эзэнгүй орхигдсон уурхайн талбайд хийх хаалтын ажлыг уурхайн хаалтын эрсдэлийн сангаас санхүүжүүлнэ.

55 дугаар зүйл. Бага эрсдэлтэй уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид санхүүгийн баталгаа бий болгох, санхүүгийн баталгаанаас чөлөөлөх

55.1. Бага эрсдэлтэй уурхай, уулын үйлдвэр хувьд эдэлбэр газрын нэгж талбайд ногдох жишиг зардлаар хаалтын зардлыг тодорхойлно:

55.1.1. дэд бүтэц, уурхайн барилга байгууламжуудад ашиглагдаж буй талбайн 1 га тутамд хоёр сая төгрөг төгрөг;

55.1.2. ил уурхай, хөрсний овоолго, далд уурхайн нуралт, цөмрөлт явагдах эрсдэл бүхий талбайн 1 га тутамд таван сая төгрөг;

55.2. Хаалтын санхүүгийн баталгаанаас дараах байдлаар хэсэгчилэн чөлөөлнө:

55.2.1. хаалтын төлөвлөгөөнд уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа явагдаж байх явцад хийж гүйцэтгэхээр тусгагдсан ажил хийгдэж, үр дүн нь мониторингоор батлагдсан, цаашид уурхайн үйл ажиллагааны улмаас тухайн үр дүнд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзсэн тохиолдолд тухайн ажилд анх тооцож барьцаалсан зардлын 30 хувийг хаалтын төлөвлөгөөний тодотголд тулгуурлан буцааж болно;

55.2.2. хаалтын төлөвлөгөөнд тусгасан бүх ажлыг хийж гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ажилд анх тооцож барьцаалсан зардлын 30 хувийг буцааж болно;

55.2.3. хаалтын зардлыг хэсэгчилэн буцаасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага дахин шийдвэр гаргана.

55.3. Хаалтын гэрчилгээ олгогдсон тохиолдолд бага эрсдэлтэй уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийг хаалтын барцаанаас бүрэн чөлөөлнө.

56 дугаар зүйл. Хаалтын төлөвлөгөөний хөндлөнгийн аудит

56.1.Уурхай, уулын үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь хаалтын төлөвлөгөөг шийдвэрлүүлсэн, төлөвлөгөөг шинэчилсэнээс хойш 2 жил тутамд мэргэшсэн этгээдээр хөндлөнгийн аудит хийлгэнэ.

56.2.Энэ хуулийн 56.1-д заасан хөндлөнгийн аудитыг төрийн захиргааны байгууллагын баталсан журмын дагуу хийнэ.

56.2.1.хөндлөнгийн аудит хийх байгууллага нь уул уурхай, байгаль орчин, санхүүгийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтэнтэй байна.

56.3.Хөндлөнгийн аудитын тайланг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх ба уг тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

56.4.Аудитын тайлангийн үнэмшил, бодит байдалд тухайн тайланг боловсруулсан хуулийн этгээд хариуцна.

56.5.Тайлан бодит байдалтай нийцээгүй, буруу дүгнэлт, зөвлөмж гаргасан бол тухайн байгууллага ёс зүйн хариуцлага хүлээх ба төрийн захиргааны байгууллага аудит хийх эрхийг хасуулах асуудлаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

56.6.Аудитын тайлан нь олон нийтэд нээлттэй байна.

57 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч хаалтын төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болох

57.1.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь хаалтын төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэж чадахгүй болох, хаалтын ажлын үр дүн хаалтын төлөвлөгөөнд заасан түвшинд хүрэхгүй болох тохиолдолд төрийн захиргааны байгууллага хаалтын төлөвлөгөө хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн тухай оролцогч талуудад мэдэгдэнэ.

57.2.Хаалтын **шалгуур үзүүлэлт хангагдаагүй гэж хаалтын комисс дүгнэлт гаргасан бол** төрийн захиргааны байгууллага хаалтын төлөвлөгөө хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн тухай оролцогч талуудад мэдэгдэнэ.

57.3.Энэ хуулийн 57.1, 57.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд төрийн захиргааны байгууллага хаалтын барьцааг ашиглан хаалт хийх ажлыг зохион байгуулна.

57.4.Энэ хуулийн 57.1, 57.2-т заасан нөхцөл байдал үүсч мөн хуулийн 51.3-ын дагуу хаалт хийсэн нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчны бусад хуулиар хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

57.5.Энэ хуулийн 57.1, 57.2-т заасан нөхцөл байдал үүссэнийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ тухай тайлбарыг төрийн захиргааны байгууллагад 30 хоногийн дотор ирүүлнэ.

57.6.Хаалтын эрсдэл нь хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд ноцтойгоор нөлөөлөхөөр байх тохиолдолд төрийн захиргааны байгууллага нь хаалтын барьцааг татан авч, зарцуулах эрхтэй.

58 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагааг түр зогсоох

58.1.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагааг түр зогсоох тохиолдолд уурхайн байгууламжуудын арчилгаа үйлчилгээ, түр зогсолтын үед байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлсон төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагад ирүүлж зөвшөөрөл авна.

58.2.Түр зогсоох төлөвлөгөө 2 хүртэл жил хүчинтэй бөгөөд уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь түр зогсоох төлөвлөгөөг шинэчилэн ирүүлж мөн хугацаагаар хоёр удаа сунгуулж болно.

58.3.Түр зогсоох хугацааны сунгалтын хуулиар зөвшөөрөгдсөн хугацаа хэтэрсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллага хаалтын барьцааг татан авна.

59 дүгээр зүйл. Гэнэтийн хаалт

59.1.Бүтээгдэхүүний үнэ ханшны уналт болсон, давагдашгүй хүчин зүйл тохиолдсон, уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж дампуурсан зэрэг тохиолдолд гэнэтийн хаалт хийнэ.

59.2.Гэнэтийн хаалтын нөхцөл байдал үүссэн тохиолдолд уурхай, уулын үйлдвэрийг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй болгож, ажиллагсдад сул зогсолтын цалин хөлс олгох асуудлыг шийдвэрлэнэ.

59.3.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж дампуурсан бол төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 59.2-т заасан ажлыг хаалтын эрсдэлийн сангаас санхүүжүүлнэ.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ил тод байдлыг хангах

60 дугаар зүйл. Ил тод байдлыг хангах

60.1.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь ил тод байдлыг хангах зорилгоор энэ хуульд заасны дагуу анхан шатны тайлан гаргах үүрэгтэй.

60.2.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан нь дор дурдсан төрөлтэй байна:

60.2.1.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ил тод байдлын анхан шатны тайлан;

60.2.2.төрийн байгууллагын ил тод байдлын анхан шатны тайлан;

60.2.3.нэгдсэн тайлан.

61 дүгээр зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн анхан шатны тайлан

61.1.Уурхай болон уулын үйлдвэр эрхлэгч аж ахуй, нэгж байгууллага нь тухайн жилд үйл ажиллагаа явуулсан, явуулаагүйгээс үл хамаарч ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл хүчинтэй байх хугацааны туршид анхан шатны тайланг жил бүр гаргана.

61.2.Ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн хүрээнд туслан гүйцэтгэгч ажиллуулж байгаа нөхцөлд тэдгээр хуулийн этгээд нь ил тод байдлын тайланг тус тусдаа гаргана.

61.3.Энэ хуулийн 61.1-д заасан тухайн жилийн анхан шатны тайланг Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-д заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

61.4.Хуулийн этгээд нь анхан шатны тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:

61.4.1.татвар болон татварын бус төлбөрийн талаарх мэдээлэл;

61.4.2.төрийн эзэмшил дэх хувьцаа, түүнтэй адилтгах үнэт цаасны хувь хэмжээ;

61.4.3.ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл;

61.4.4.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн жагсаалт, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь хэмжээ;

61.4.5.олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, борлуулалтын үнэ, орлогын хэмжээ;

61.4.6.үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагатай байгуулсан гэрээний талаарх мэдээлэл;

61.4.7.нийгмийн болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл, уг хөрөнгө оруулалтын хэмжээ;

61.4.8.нөхөн сэргээлт болон хаалтын санд төлөврүүлж байгаа зардал, түүний зарцуулалт, барьцааны талаарх мэдээлэл, хэмжээ;

61.4.9.ажиллах хүч, ажлын байрны талаарх мэдээлэл;

61.4.10.төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн хандив, тусламж зэрэг татварын бус төлбөрийн талаарх мэдээлэл, хэмжээ;

61.5.Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уурхай болон уулын үйлдвэр эрхлэгч хуулийн этгээд нь анхан шатны тайланг дээрхийн адил гаргана.

61.6.Уурхай болон уулын үйлдвэр эрхлэгч хуулийн этгээд анхан шатны тайланд туссан мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

61.7.Анхан шатны тайлан гаргагч уурхай болон уулын үйлдвэр эрхлэгч хуулийн этгээд дор дурдсан эрх, үүрэгтэй байна.

61.7.1.энэ хуульд заасан анхан шатны тайланг энэ хуулийн 61.3-т заасан хугацаанд Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтын дагуу гаргах;

61.7.2.анхан шатны тайланг гаргахдаа шаардлагатай тайлбар, тодруулгыг бүрэн өгөх, холбогдох материалыг хавсаргах;

61.7.3.ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой сургалт, мэргэжил арга зүйн туслалцааг холбогдох байгууллагаас авах хүсэлт гаргах, уг туслалцааг үнэ төлбөргүй авах;

61.7.4.ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой тодруулга, мэдээллийг холбогдох байгууллагаас авах;

61.7.5.нэгдсэн тайлангийн хувийг авах, уг тайланг үйл ажиллагаандаа ашиглах.

62 дугаар зүйл. Төрийн байгууллагын ил тод байдлын анхан шатны тайлан

62.1.Дор дурдсан төрийн байгууллага нь төрийн байгууллагын ил тод байдлын анхан шатны тайлан гаргана:

62.1.1.Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

62.1.2.Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

62.1.3.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

62.1.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1-д заасан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

62.1.5.Авто замын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

62.1.6.Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

62.1.7.Татварын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

62.1.8.Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

62.1.9.Гаалийн тухай хуулийн 267 дугаар зүйлийн 267.2-т заасан гаалийн удирдах төв байгууллага;

62.1.10.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан мэргэжлийн хяналтын төв байгууллага;

62.1.11.Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

62.1.12.Цөмийн энергийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

62.1.13.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Төрийн өмчийн хороо;

62.1.14.Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан нийгмийн даатгалын төв байгууллага;

62.1.15.Стандарчлал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан Стандарчлалын төв байгууллага, түүний бүтэц дэх үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулууны чанарын улсын хяналт тавих чиг үүрэг бүхий нэгж;

62.1.16.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага;

62.1.17.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдах төв байгууллага;

62.1.18.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар;

62.1.19.Үндэсний зөвлөлийн шийдвэрээр тогтоосон төрийн бусад байгууллага.

62.2.Сум, дүүргийн Засаг дарга нь сум, дүүргийн тухайн жилийн анхан шатны тайланг дараа оны дөрөвдүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад гарган хүргүүлэх бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга нь аймаг, нийслэлийн тухайн жилийн анхан шатны тайланг дараа оны тавдугаар сарын 01-ний дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гарган хүргүүлнэ.

62.3.Энэ хуулийн 62.1-д заасан төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллага нь тухайн жилийн анхан шатны тайланг дараа оны тавдугаар сарын 01-ний дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гарган хүргүүлнэ.

62.4.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ зүйлийн 60.2 болон 60.3-т заасан анхан шатны тайланг нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны тавдугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

62.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 62.4-т заасан төрийн захиргааны анхан шатны тайлангийн нэгтгэлийг хянаж баталгаажуулсны үндсэн дээр зургадугаар сарын 15-ны дотор Ажлын албанд хүргүүлнэ.

62.6.Төрийн захиргааны анхан шатны тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:

62.6.1.орлогын дүн, хуваарилалт, орлогын тогтвортой байдлын талаарх мэдээлэл;

62.6.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр төрийн эзэмшлийн хувь хэмжээ, хувьцаа болон түүнтэй адилтгах үнэт цаасны тоо хэмжээ;

62.6.3.олгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл;

62.6.4.тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн жагсаалт, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь хэмжээ;

62.6.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч, тус компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ;

62.6.6.тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр тэдгээртэй байгуулсан ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагын зүгээс тэдгээртэй байгуулсан гэрээний талаарх мэдээлэл;

62.6.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр нийгмийн болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалтын хэмжээ;

62.6.8.уурхай тус бүрээр нөхөн сэргээлтийн зардал, түүний зарцуулалт, барьцааны талаар мэдээлэл;

62.6.9.тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр ажиллах хүч, ажлын байрны талаарх мэдээлэл;

62.6.10.төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн;

62.6.11.эрдэс баялгийн салбараас Монгол Улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр;

62.6.12.тайлангийн маягад заасан бусад мэдээлэл.

62.7.Төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн төрийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.

62.8.Энэ хуулийн 62.1-д заасан төрийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогтой холбоотой тэдгээрийн гаргах анхан шатны тайланд нэмэлт мэдээлэл тусгахаар Үндэсний зөвлөлөөс шийдвэр гаргаж болно.

62.9.Төрийн байгууллагын тайлан гаргагч бүр тус бүрийн гаргасан ил тод байдлын тайланд туссан мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

63 дугаар зүйл.Нэгдсэн тайлан

63.1.Энэ хуулийн 67.4-д заасан Үндэсний зөвлөл нь сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгарсан эрх бүхий хуулийн этгээд (цаашид “тайлан нэгтгэгч” гэх)-ээр тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, төрийн байгууллагаас гаргасан тайланг тулган нэгтгэх ажлыг гүйцэтгүүлэхээр хүсэлт хүргүүлнэ.

63.2.Тайлан нэгтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Үндэсний зөвлөлөөс байгуулсан Үнэлгээний хороо зохион байгуулж, шалгарсан тайлан нэгтгэгчийг олон нийтэд мэдээлнэ.

63.3.Ажлын алба нь энэ хуулийн 61.1, 62.1-д тус тус заасны дагуу ирүүлсэн тайланг тайлан нэгтгэгчид хүргүүлэх бөгөөд тайлан нэгтгэгч нь нэгдсэн тайланг гурван сарын дотор бэлтгэж Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулна.

63.4.Үндэсний зөвлөл нь нэгдсэн тайланг дараа оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэлэлцэж, хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар батлан олон нийтэд мэдээлэх ба батлагдсан нэгдсэн тайланг Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газарт хүргүүлнэ.

63.5.Нэгдсэн тайланд энэ хуулийн 59, 60 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон төрийн байгууллагаас гаргасан тайлангуудын тэнцлийг тусгахаас гадна дор дурдсан мэдээллийг тусгана:

63.5.1.улсын эдийн засагт эрдэс баялгийн салбарын эзлэх хувь хэмжээ;

63.5.2.эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай;

63.5.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр болон нэгж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ;

63.5.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон төрийн байгууллагын ил тод байдлын тайлан хоорондын зөрүү, түүний тайлбар, тодруулга;

63.5.5.ил тод байдлын тайлан ирүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагын талаарх мэдээлэл;

63.5.6.ил тод байдлын тайланг нэгтгэх явцын талаар нэгтгэгчийн зүгээс гарсан дүгнэлт, зөвлөмж;

63.5.7.ил тод байдлын тайлангууд хоорондын зөрүүг илрүүлэх ажиллагааны үр дүн, танилцуулга;

63.5.8. тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төрийн бус байгууллагад өгсөн хандив, тусламжийн дүн;

63.5.9. төрийн байгууллагаас төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн;

63.5.10. нэгдсэн тайлангийн маягтад заасан бусад мэдээлэл.

63.6. Үндэсний зөвлөлөөс нэгдсэн тайлангийн төслийг хангалтгүй гэж үзвэл тайланг ажлын албанд буцаах бөгөөд Ажлын алба нь нэгдсэн тайланг эцэслэн боловсруулах ажлыг тайлан нэгтгэгчээр гүйцэтгүүлнэ.

63.7. Тайлан нэгтгэгч нь нэгдсэн тайлангийн талаар Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, шүүмжлэлийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж нэгдсэн тайланг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор эцэслэн ажлын албанд хүргүүлнэ. Ажлын алба нь эцэслэн боловсруулсан нэгдсэн тайланг Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна.

63.8. Ажлын алба Үндэсний зөвлөлөөс батлагдсан нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хэвлэн олшруулах, Ажлын албаны цахим хуудсанд байршуулах зэргээр олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

64 дүгээр зүйл. Ил тод байдлын анхан шатны тайлан хоорондын зөрүүг хянан шийдвэрлэх

64.1. Тайлан нэгтгэгч нь анхан шатны тайланг нэгтгэх явцад тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон төрийн байгууллагаас тэдгээрийн гаргасан анхан шатны тайланд тусгасан мэдээллийг тодруулах, нэмэлт мэдээлэл авах эрхтэй байна.

64.2. Тайлан нэгтгэгч нь энэ хуулийн 64.1-д заасан хүсэлтийг тухайн тайлан гаргасан хуулийн этгээдэд албан бичгээр хүргүүлэх бөгөөд үүссэн зөрүүний талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлнэ.

64.3. Энэ хуулийн 64.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан хуулийн этгээд хариуг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор тайлан нэгтгэгчид бичгээр өгнө.

64.4. Тайлан нэгтгэгч нь энэ зүйлийн 64.3-т заасан хариуг хүлээн авсны дараа зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн тухай ажлын 10 хоногийн дотор хариу ирүүлсэн хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ. Шаардлагатай тохиолдолд тайлан гаргагч хуулийн этгээд нь зөрүү үүсгэж байгаа нөгөө талын тайлан гаргагчийн тайлантай танилцаж болно.

64.5. Тайлан нэгтгэгч нь энэ зүйлийн 64.3-т заасан мэдээлэлд үндэслэн тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй байна гэж үзсэн тохиолдолд энэ талаар

тайлбар, зөвлөмжийг нэгдсэн тайлангийн төсөлд тусгах ба хэрхэн тусгасан талаар анхан шатны тайлан гаргасан хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

64.6. Анхан шатны тайлан гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, эсхүл төрийн байгууллагаас энэ зүйлийн 64.3-т заасан хугацаанд хариу ирүүлээгүй нөхцөлд тайлан нэгтгэгч нь энэ талаар Ажлын албанд тухай бүр мэдэгдэнэ.

64.7. Анхан шатны тайлан гаргасан хуулийн этгээдээс хүсэлт гаргасан тохиолдолд Ажлын алба нь холбогдох зөвлөмж, мэргэжлийн арга зүйгээр ханган, уг тайлан гаргагчийг сургалтад хамруулж болно.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Салбарын удирдлага, зохион байгуулалт

65 дугаар бүлэг. Уул уурхайн салбарын удирдлага, зохион байгуулалтын талаарх төрийн зохицуулалт

65.1. Төрийн захиргааны төв байгууллагын дэргэд зөвлөх чиг үүрэг бүхий Бодлогын зөвлөл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын Үндэсний зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хороо тус тус ажиллана.

65.2. Төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах ба тэдгээрт төрийн зарим чиглэлийг шилжүүлэн ажиллаж болно.

65.3. Төрийн захиргааны төв байгууллага нь стандартын шаардлага хангасан мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

65.4. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь тэдгээртэй байгуулсан санамж бичиг, гэрээний хүрээнд салбарын суурь судалгаа боловсруулах талаар хамтран ажиллаж болно.

65.5. Төрийн захиргааны байгууллага нь үндсэн бүтэцдээ бодлогын судалгааны, байгаль орчны нэгжтэй байхаас гадна хуулиар хүлээсэн өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх төлөөлөгчийн газрыг бүсчилсэн байдлаар байгуулан ажиллуулж болно.

66 дугаар зүйл. Уул уурхайн салбарын хүний нөөц бэлтгэх

66.1. Төрийн захиргааны төв байгууллага нь уул уурхайн салбарын хүний нөөц, мэргэжилтэй боловсон хүчний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, судалгаа хийх зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

66.1.1.уул уурхайн мэргэжлийн их, дээд боловсролын байгууллагатай түүний сургалтын хөтөлбөрийн агуулга, мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээ, шаардлагын талаар санал хүргүүлж болно.

66.1.2.тусгай мэргэжлийн сургалт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт эрхлэн явуулдаг аж ахуйн нэгжүүдийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад оролцоно.

67 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгчийн удирдлага зохион байгуулалтын талаарх үүрэг

67.1.Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд тавигдах шаардлагыг хангаж ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь уурхайн үйл ажиллагааг мэргэжлийн багаар удирдуулан явуулна.

67.2.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь мэргэжлийн баг бүрдүүлэх боломжгүй тохиолдолд мэргэжлийн олборлогч компанид уурхайн олборлолтын үйл ажиллагааг гэрээгээр хариуцуулан гүйцэтгүүлнэ.

67.3.Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулагч аж ахуйн нэгж нь жилд хамгийн багадаа 1 удаа өөрийн инженер техникийн ажилтнуудыг мэргэжлийн сургалтанд хамруулна.

68 дугаар зүйл. Уурхайн удирдах ажилтанд тавигдах шаардлага

68.1.Уурхайн ерөнхий менежерт дараах шаардлага тавигдана.

68.1.1.уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө уурхайн ерөнхий менежерийг томилсон байна.

68.1.2.уурхайн ерөнхий менежер буюу дарга нь уул уурхайн мэргэжил эзэмшсэн, салбартаа 10 жилээс доошгүй жил ажилласан, удирдах албан тушаалд 5 жилээс доошгүй жил ажилласан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна

68.1.3.уурхайн үндсэн ажил олгогч нь уурхайн ерөнхий менежерийг томилсон тохиолдол бүрт энэ тухай болон шинээр томилогдсон уурхайн ерөнхий менежерийн овог, нэр, хаягийг тухайн уурхайн байрлаж байгаа мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

68.1.4.уурхайн ерөнхий менежер нь энэхүү хуулийн дагуу уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг хянаж удирдана.

68.2. Уурхайн менежерт дараах шаардлага тавигдана.

68.2.1. уурхайн үндсэн ажил олгогч уурхайн ажилд хяналт тавин удирдах чадавхи, туршлага бүхий ажилтныг уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцуулахаар томилно.

68.2.2. уурхайн менежер нь уурхайн ашиглалтын технологи чиглэлээр мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн байна.

69 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах орон тооны бус зөвлөлийн чиг үүрэг

69.1. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоодын төлөөлөл орж ажиллана.

69.2. Ашигт малтмалын тухай хуулийн 48.3-т заасан тайлан хэлэлцэж дүгнэлт гаргахдаа ашигт малтмалын ордыг энэ хуулийн 6.1, 6.2, 6.3-д заасан ангиллын алинд нь хамааруулах талаарх саналыг төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

69.3. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл нь улсын хэмжээний буюу эрсдэл ихтэй уурхай, уулын үйлдвэрийн дараах тайлан, төлөвлөгөөг хэлэлцэж дүгнэлт гарган шийдвэрлүүлэх саналыг төрийн захиргааны төв байгууллагын даргад хүргүүлнэ.

69.3.1. уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөө

69.3.2. уурхай, уулын үйлдвэрийн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан

69.3.3. уурхай, уулын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл

69.4. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг хараат бусаар, мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн олонхийн саналд үндэслэн гаргах бөгөөд гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээнэ.

69.5. Уурхай, уулын үйлдвэрийн ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэдээлэл, сурталчилгаа хийх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн шалтгааны талаар судалгаа хийлгэж дүгнэлт, санал гаргах, үүрэг бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог байгуулж ажиллуулна.

69.4.1. салбар хорооны бүрэлдэхүүнд төрийн байгууллага, ажил олгогч, ажилтны адил тэнцүү төлөөлөл орсон байна.

69.5.Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хэрэгжүүлэх үүрэгтэй Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулна.

69.5.1.Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд даргалах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд дор дурдсан төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон иргэний нийгмийн эвслийн төлөөлөл орсон байна.

69.6.Үндэсний зөвлөл нь Ажлын албатай байх ба Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөлийн хуралдаанаас томилно.

69.7.Үндэсний зөвлөл нь жил бүр үйл ажиллагааны тайлан гаргаж Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэхээс гадна уг тайланг Ажлын албаны цахим хуудсанд байнга байрлуулна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Маргааныг хянан шийдвэрлэх

70 дугаар зүйл. Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх

70.1.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь энэ хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж болно.

70.2.Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын санхүүгийн баталгаа, эрсдлийн сантай холбоотой маргааныг төрийн захиргааны төв байгууллага санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

70.3.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь хайгуулын үр дүнд тогтоосон нөөц, нөөцийн балансын асуудлаар төрийн захиргааны байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

70.4.Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь нарийвчилсан хайгуулын үр дүнгээр тогтоосон нөөцийг үндэслэлгүйгээр дутааснаа хүлээн зөвшөөрөөгүйгээс үүссэн маргааныг төрийн захиргааны байгууллага шүүхээр шийдвэрлүүлнэ.

70.5. Уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой бусад маргааныг холбогдох дээд шатны төрийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ. Тэдгээр байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

УУЛ УУРХАЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

2016 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл

2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгогдсон ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгчид уурхай, уулын үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөг энэ хуультай нийцүүлэн 3 жилийн хугацаанд шинээр боловсруулж баталгаажуулна.

2 дугаар зүйл

2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлж байсан хуулийн этгээдийн үйл ажиллагаа энэ хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргаж бүртгэлжүүлэх асуудлыг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн хугацаанд энэ хуультай нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

3 дугаар зүйл

2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө холбогдох хуулийн дагуу уурхайн чиглэлээр зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг энэ хуулийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн бүртгэж шинээр тусгай зөвшөөрөл олгох асуудлыг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн хугацаанд энэ хуультай нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

4 дүгээр зүйл

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хадгалах тусгай зөвшөөрөл авах тохиолдолд хүсэлтийг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн хугацаанд гаргана.

5 дугаар зүйл

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу олгогдсон хадгалах тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахад хадгалах тусгай зөвшөөрөл олгох үлдсэн байсан хугацаагаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгоно.

6 дугаар зүйл

Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2016 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 6.17 дугаар зүйл нэмсүгэй. “6.17 дугаар зүйл. Уул уурхайн тухай хууль зөрчих

1.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөлгүйгээр олборлосон, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ барьцаалсан, хадгалсан бол хувь хүнийг хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хаалтын төлөвлөгөөгөө баталгаажуулж хаалтын санхүүгийн баталгааны гэрчилгээ авалгүйгээр уурхай, уулын үйлдвэрийн үйл ажиллагаа явуулсан бол хувь хүнийг хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Ашигт малтмалын нөөцийн балансыг баталгаажуулаагүй, үндэслэлгүйгээр нөөц дутаасан бол дутаасан нөөцөд ноогдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нөхөн төлүүлж хувь хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Ашигт малтмалын ордыг сорчлон ашигласан нь тогтоогдвол хувь хүнийг хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 23 дугаар зүйл:

“23 дугаар зүйл. Хадгалах тусгай зөвшөөрөл

23.1.Хайгуулын ажлын үр дүнд ашигт малтмалын орд тогтоогдож түүний нөөцийг нь улсын бүртгэлд бүртгэснээс хойш хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө хадгалах тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж болно.

23.2.Хадгалах тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл авах нөхцлийг хангаж хүсэлт гаргаагүй бол тусгай зөвшөөрлийг цуцлана.

23.3.Хадгалах тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгож 5 жилээр нэг удаа сунгуулж болно.

23.4.Хадгалах тусгай зөвшөөрлийн хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргавал ашиглалтын тусгай зөвшөөрлийг энэ хуулийн заасан журмын дагуу олгож болно.

23.5.Хадгалалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 23.3-т заасан хугацаанд мөн хуулийн 32.3-т заасан төлбөрийг төлнө.”

2/ 25 дугаар зүйлийн 25.1.9 дэх заалт:

“25.1.9.тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл.”

3/ 25 дугаар зүйлийн 25.1.10 дахь заалт:

“25.1.10.уурхайн хаалтын төлөвлөгөө.”

4/ 32 дугаар зүйлийн 32.2² дахь хэсэг:

“32.2². Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.6-д заасны дагуу жил бүр төлнө.”

5/ 35 дугаар зүйлийн 35.3.8 дахь заалт:

“35.3.8.уурхайн хаалтын төлөвлөгөө.”

6/ 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг:

“45.3. Уурхай, уулын үйлдвэрийн хаалттай холбогдсон асуудлыг Уул уурхайн тухай хуулиар зохицуулна.”

7/ 47 дугаар зүйлийн 47.1¹ дэх хэсэг:

“47.1¹. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө.”

8/ 49¹ дүгээр зүйл:

“49¹ дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг нэгтгэх

49¹.51. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хил залгаа орших өөрийн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг нэгтгэн ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох хүсэлт гаргах бол тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудын ядаж нэг нь нөөц нь тогтоогдсон байх шаардлагатай.

49¹.2. Хил залгаа орших хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид өөр өөрсдийн тусгай зөвшөөрлүүдийг нэгтгэх, эсхүл уул уурхайн төслийн тодорхой үе шатуудад хамтран ажиллахаар тохиролцсон бол техник, эдийн засгийн үндэслэл болон түүнд холбогдох бусад бичиг баримтыг хамтран боловсруулж болно.

49¹.3. Хил залгаа орших тусгай зөвшөөрлийг нэгтэхдээ тусгай зөвшөөрлүүдийг тоо, талбайн хэмжээ хамааралгүй нэгтгэх ба энэ тохиолдолд шинээр нэгтгэн олгох ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг хамгийн сүүлд дуусах тусгай зөвшөөрлийн хугацаагаар олгоно.”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.1 дэх заалтын “нүүрс болон ...” гэсний дараа “түгээмэл тархацтай ашигт малтмалын ...” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т “”стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг” гэснийг “”стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоол, мөн Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр тогтоолд

заасан ордыг”, мөн хуулийн 24.2-т “ашиглалтын” гэснийг “хайгуулын” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “болон түгээмэл тархацтай” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.19, 11.1.20 дахь заалтын “түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг, 39.1.1-д “сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1, 42.5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.6.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

2016 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Байгаль орчны үнэлгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай 7.8, 7.9 дэх хэсгийг нэмсүгэй.

1/ 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг:

“7.8.Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.”

2/ 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг:

“7.9.Уул уурхайн төслийн үнэлгээний шинжээч болон тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах ерөнхий шинжээчийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.”

2 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай өөрчлөлт оруулсугай.

“8.7-т “...байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага...” гэснийг “...байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага...” гэж, 9.10-т “Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь...” гэснийг “Химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь...” гэж, 9.11-т “...уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт...” гэснийг “...үйлдвэрийн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт...”, “...уурхайн хаалтын үе шатанд буцаан олгоно.” гэснийг “...үйлдвэрийн хаалтын үе шатанд буцаан олгоно.” гэж, 9.12-т “Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний...” гэснийг “Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын төлөвлөгөөний...” гэж, 10.2-т “...байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий

шинжээч уг тайланд үнэлгээний шинжилгээ хийх шинжээчдийн баг томилно.” гэснийг “...байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, эсхүл уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч уг тайланд үнэлгээний шинжилгээ хийх шинжээчдийн баг томилно.” гэж, 10.3-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч...” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн, эсхүл уул асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч...” гэж, 10.4-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага...” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн эсхүл уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага...” гэж, 11.2-т “...байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч тогтоож...” гэснийг “...байгаль орчны асуудал эрхэлсэн эсхүл уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч тогтоож...” гэж, 11.4-т “...байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад саадгүй бүрдүүлж өгнө.” гэснийг “...байгаль орчны асуудал эрхэлсэн эсхүл уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад саадгүй бүрдүүлж өгнө.” гэж, 14.1.3-т “...газрын тос болон уул уурхайн төслүүд нь...” гэснийг “...газрын тосны төслүүд нь...” гэж тус тус.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2016 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 23 дахь заалт нэмсүгэй.

1/ 15 дугаар зүйлийн 15.10.23 дахь заалт:

“15.10.23.уул уурхайн төслийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ

2016 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт нэмсүгэй.

1/ 25 дугаар зүйлийн 25.1.12 дахь заалт:

“25.1.12. уул уурхайн төлийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах тусгай зөвшөөрөл олгох, сунгахад 1 000 000 төгрөг”.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр батлагдсан Уул уурхайн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ний өдөр батлагдсан Уул уурхайн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД